

# СПОРТЫН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

ТАЙЛАН

Улаанбаатар хот  
2022 он

*“Улаанбаатар Спорт менежмент” ХК-ийн захиалгаар судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эс Ай Си Эй” ХХК гүйцэтгэв.*

1

СУДАЛГААНЫ  
ТУХАЙ

2

САЛБАРЫН  
ӨНӨӨГИЙН  
БАЙДАЛ

3

СУДАЛГААНЫ ҮР  
ДҮН

4

ДҮГНЭЛТ

5

ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ  
САНАЛ БОЛГОХ  
ХУВИЛБАР

6

ХАВСРАЛТ



# СУДАЛГААНЫ ТУХАЙ

1. ЗОРИЛГО, ЗОРИЛТ
2. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ
3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ
4. МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ БОЛОН ХЯНАЛТ

1

## ЗОРИЛГО, ЗОРИЛТ

## ЗОРИЛГО


Энэхүү зөвлөх үйлчилгээний зорилго нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй биеийн тамир, спортын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд болон шигшээ багийн тамирчдаас **спорт байгууламжийн одоогийн хүртээмж, бэлтгэлийн баазын чанар стандарт, бусад хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, спорт цогцолбортой холбоотой олон улсын туршлагыг судалж одоо баригдаж байгаа спорт цогцолборын өрсөлдөх чадвар, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох.**

## ЗОРИЛТ

Үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж, ажилласан. Үүнд:

- Салбарын өнөөгийн нөхцөл байдлыг баримт бичгийн судалгаа хийж тодорхойлох
- Өрсөлдөгч спорт цогцолборуудыг судлах
- Олон улсад амжилттай үйл ажиллагаагаа явуулж буй спорт цогцолборуудын сайн туршлагуудыг судлах
- Мэргэжлийн байгууллага болон тамирчдын зүгээс спорт байгууламжийн хүртээмж, нөхцөл байдлыг хэрхэн тодорхойлж байгаа талаар болон цаашдын хэрэгцээ, шаардлагыг тодруулах
- Судалгааны үр дүнд үндэслэн одоо баригдаж байгаа спорт цогцолборын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон хувилбарууд санал болгох

## СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ



### Спортын мэргэжлийн байгууллага, холбоо, тамирчидтай хамтран ажиллах

#### Спортын мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран ажиллах

- Спортын мэргэжлийн тамирчдад зориулсан бэлтгэлийн бааз
- Спортын төрөл бүрийн тэмцээн зохион байгуулах

#### Спортын мэргэжлийн тамирчин бэлтгэх клуб байгуулах

### Бусад боломжууд

#### Салбар хоорондын томоохон тэмцээн зохион байгуулах (Уул уурхай, банк, санхүү гэх мэт)

#### Спорт цогцолборын нэрийг тодорхой хугацаанд томоохон байгууллагуудын нэрэмжит болгох

#### Энтертайнмент үйл ажиллагаа зохион байгуулах

- Урлаг, соёлын алдартнуудын тоглолт зохион байгуулах
- Томоохон хувийн хэвшлийн байгууллагуудын шинэ жил, ойн баяр гэх мэт тэмдэглэлт баярын үйл ажиллагааг зохион байгуулах

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

ТООН СУДАЛГАА

+

ЧАНАРЫН СУДАЛГАА

||



Түүвэр судалгаа

||



Бүлгийн, ганцаарчилсан  
ярилцлага

Судалгааг тоон болон чанарын судалгааны аргыг ашиглан зохион байгуулсан. Тоон судалгааны үр дүнг бататгах, илүү нарийвчилсан мэдээлэл олж авахын тулд чанарын судалгааг хийсэн.

## ОРОЛЦОГЧДЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Түүвэр судалгаанд 17 спортын төрлийн 120 оролцогч, чанарын судалгаанд 10 спортын төрлийн 21 оролцогч, Биеийн тамир, спортын хорооны 1 төлөөлөгч хамрагдсан.

ТООН СУДАЛГАА

39 дасгалжуулагч  
31 шигшээ багийн тамирчин  
50 шигшээ багт байдаггүй тамирчин

ЧАНАРЫН СУДАЛГАА

10 спортын холбооны дарга, менежерийн албан тушаалтан, Биеийн тамир спортын улсын хорооны 1 төлөөлөгч  
8 шигшээ багийн тамирчин





## СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨЛӨӨЛЛҮҮД

№	Спортын төрөл	№	Спортын төрөл
1	Бокс	11	Волейбол
2	Хүндийн өргөлт	12	Жюү-жицү бөх
3	Уран сайхны гимнастик	13	Чөлөөт бөх
4	Спортын гимнастик	14	Хөнгөн атлетик
5	Бодибилдинг	15	Цахим спорт
6	Холимог тулаан	16	Сагсан бөмбөг
7	Ширээний теннис	17	Усан спорт
8	Самбо бөх	18	Хараагүйчүүдийн хөл бөмбөг
9	Жүдо бөх	19	Пара хөнгөн атлетик
10	Үндэсний бөх	20	Биеийн тамир спортын улсын хороо, Үндэсний шигшээ багийн бодлого хэрэгжилтийн хэлтэс

Түүвэр болон чанарын судалгаанд хамрагдсан спортын төрөл, мэргэжлийн байгууллагуудын төлөөллийн хувьд давхцал байгаа бөгөөд бид дараах спортын төрөл, спортын мэргэжлийн байгууллагуудын төлөөллүүдийг судалгаанд хамруулсан. Монгол идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нийт 30 гаруй спортын мэргэжлийн байгууллага байгаагийн 60 гаруй хувьд хүрсэн байна.

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

## ТООН СУДАЛГАА



Нийт 120 оролцогч, 17  
спортын төлөөлөл

## Түүвэр судалгаа

Тоон судалгаа нь түүврийн дагуу тодорхой тооны хүмүүсээс урьдчилан бэлдсэн асуултаар мэдээлэл цуглуулдаг бөгөөд илүүтэй тоон үзүүлэлтээр харуулахад тохиромжтой мэдээллийг цуглуулдаг. Түүнчлэн цуглуулсан мэдээллийг ач холбогдлоор нь харьцуулан харуулах боломжтой байдаг.

## ЧАНАРЫН СУДАЛГАА




11 спортын мэргэжлийн  
байгууллага, 8 шигшээ  
багийн тамирчдын төлөөлөл

## Бүлгийн, ганцаарчилсан ярилцлага

Чанарын судалгаа нь тухайн салбарын төлөөлж чадахуйц тодорхой тооны хүмүүсийг сонгож, урьдчилан бэлдсэн асуултуудын дагуу ярилцаж мэдээлэл цуглуулдаг. Энэхүү судалгаа нь тоон судалгаагаар асууж, тодруулахад хүндрэлтэй асуудлыг гаргахаас гадна тоон судалгааны үр дүнг баталгаажуулах мэдээллийг цуглуулах боломжтой байдгаараа онцлог.




## СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙ



### **PAPI** (paper assisted personal interview)

Асуулгын хуудсаар  
мэдээлэл цуглуулах  
арга



### **CAWI** (computer assisted web interview)

Онлайнаар мэдээлэл  
цуглуулах компьютерт  
суурилсан арга



### **CATI** (computer assisted telephone interview)


Утсаар мэдээлэл  
цуглуулах компьютерт  
суурилсан арга



### **CAPI** (computer assisted personal interview)




Таблет, зөөврийн  
компьютерээр мэдээлэл  
цуглуулах арга

## ТАБЛЕТААР МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА/САРИ







## МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ БОЛОН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

- Мэдээллийн шивэлтийн алдааг шалгах:  
**Data Entry Tool and Batch Editing of CS Pro 5.0** 
- Мэдээлэл боловсруулалт:  
**SPSS Software 25.0** 
- Мэдээлэл боловсруулалт:  
**MS-Excel** 

Судалгаа, шинжилгээнд ашиглагддаг программуудын хамгийн сүүлийн хувилбаруудыг ашиглан мэдээлэл боловсруулалтыг хийсэн.

### МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТЫН ХЯНАЛТ

- Судлаачдыг бэлтгэсэн:  
**Тусгайлсан сургалтыг зохион байгуулсан** 
- Мэдээлэл цуглуулалтын хяналт:  
**SICA хянагч нар нэг бүрчлэн хянасан** 
- Мэдээлэл цуглуулалтын дараах хяналт:  
**SICA хянагч нар 80%-ийн утсаар шалгасан** 
- Мэдээлэл шивэлтийн хяналт:  
**Шивэлтийн алдааг программаар шалгасан** 

Мэдээллийн чанар хамгийн чухал тул хяналтыг алхам тутамд буюу 4 алхамаар хийж гүйцэтгэсэн. Нийт анкетын 80%-д нь утсаар хяналт хийв.

# САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1. СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


2





## СТАТИСТИК МЭДЭЭЛЛҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


Монгол Улсад бүртгэлтэй тамирчид, 2021 он





2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад бүртгэлтэй нийт 107,777 тамирчин байна.

*\*Дээрх статистик мэдээллийг гаргахдаа тамирчдыг харьяа аймгаар нь харгалзан бүртгэсэн байх магадлалтай гэж үзэж байгаа тул цаашид тооцооллыг хийхдээ бүс нутаг тус бүрд харьяалалтай тамирчдын 80 хувийг Улаанбаатар хотод бэлтгэл сургуулилт хийдэг гэж үзлээ.*

Тамирчдын хичээллэдэг спортын төрөл




Тамирчдын хичээллэдэг спортын төрөл, бүс нутгаар



## СТАТИСТИК МЭДЭЭЛЛҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Нэг тамирчин нэг жилийн хугацаанд бэлтгэл сургуулилт хийх газартаа зарцуулж буй мөнгөн дүн, **мянган төгрөгөөр**




Улаанбаатар хотод бэлтгэл, сургуулилт хийж буй нийт тамирчны нэг жилийн хугацаанд бэлтгэл сургуулилт хийх газартаа зарцуулж буй мөнгөн дүн, **мянган төгрөгөөр**






## СТАТИСТИК МЭДЭЭЛЛҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсад зохион байгуулагдсан тэмцээн уралдаан, 2021 он



2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад 1,160 спортын тэмцээн, уралдаан зохион байгуулагдсан байна.


Зохион байгуулагдсан спортын тэмцээн, уралдаан, бүс нутгаар



■ Олон улсын ■ Улсын ■ Бүсийн ■ Сум, дүүргийн ■ Аймаг, нийслэлийн

## ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА ТОДОРХОЙЛСОН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Тамирчдын тогтмол оролцдог үндэсний болон ОУ-ын тэмцээнүүд, *сараар*



## ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА ТОДОРХОЙЛСОН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Тамирчдын тогтмол оролцдог үндэсний болон ОУ-ын тэмцээнүүд, *сараар*

I сар	II сар	III сар	IV сар	V сар	VI сар
Deaf Холбооны тэмцээн				Оюутны лиг	
Дэлхийн аварга				Дээд лиг	
Дээд лиг				MGL-1	
Заалны тэмцээн	Улсын аварга	Road to one Mongolia	Оюутны лиг	Сар болгоны барилдаан	Улсын аварга
Оросын ОУ тэмцээн	Оюутны лиг	Оюутны лиг	Улсын аварга	Хотын аварга	Сар болгоны барилдаан
Оюутны лиг	Дээд лиг	Улсын аварга	Оюутны лиг	УБ марафон	барилдаан
Өсвөрийн аварга	Оюутны лиг	Дээд лиг	Улсын аварга	MGL-1	Челленжер лиг
Сар болгоны барилдаан	Насанд хүрэгчдийн аварга	Сар болгоны барилдаан	Сар болгоны барилдаан	Улсын аварга	Бодибилдинг
Үндэсний шигшээ багийн аварга	Сар болгоны барилдаан	Хотын аварга	Залуучуудын чөлөөт бөхийн	Хотын аварга	фитнесийн улсын аварга
аварга	Азийн аварга	Челленжер лиг	Хотын аварга	МУ хөл бөмбөгийн лиг	шалгаруулах тэмцээн
Улсын аварга	Заалны тэмцээн	Сөүл марафон	ESEA	Заалны тэмцээн	Азийн аварга
Чөлөөт бөхийн улсын аварга		Заалны тэмцээн	Заалны тэмцээн	Фен клубийн лиг	
				S зэрэглэлийн тэмцээн	
				Үндэсний шигшээ багийн аварга	

## ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА ТОДОРХОЙЛСОН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Тамирчдын тогтмол оролцдог үндэсний болон ОУ-ын тэмцээнүүд, *сараар*

VII сар	VIII сар	IX сар	X сар	XI сар	XII сар
Улсын аварга	Дэлхийн аварга		Улсын аварга		
Сар болгоны барилдаан	Аймгийн наадам		Оюутны лиг	Оюутны лиг	Оюутны лиг
Челленжер лиг	Сар болгоны барилдаан	Дэлхийн аварга	Үндэсний дээд лиг	Оргилуун лиг	Дүүргийн аварга
Бодибилдинг фитнесийн	Улсын аварга	Сар болгоны барилдаан	Хөл бөмбөгийн аварга	Сар болгоны барилдаан	Дээд лиг
улсын аварга шалгаруулах	Азийн аварга	U18 2021, 2022	Оргилуун лиг	Залуучуудын чөлөөт бөхийн	Залуучуудын чөлөөт бөхийн
тэмцээн	Насанд хүрэгчдийн улсын аварга	Заалны тэмцээн	Сар болгоны барилдаан	Залуучуудын чөлөөт бөхийн	улсын аварга
Азийн аварга	Заалны тэмцээн	Mesa pro series	Самбо бөхийн дэлхийн аварга	улсын аварга	Челленжер лиг
	Mesa pro series		Өсвөрийн аварга	Улсын аварга	Улсын аварга
			Залуучуудын аварга	Дэлхийн аварга	Жиг жуг
			Дүүргийн аварга	Заалны тэмцээн	Заалны тэмцээн
			Заалны тэмцээн	Үндэсний шигшээ багийн аварга	Үндэсний шигшээ багийн аварга
			Сонирхогчдын аварга		
			Үндэсний шигшээ багийн аварга		

## 2023 ОНЫ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ХУВААРЬ

I сар	II сар	III сар	IV сар	V сар	VI сар
<ul style="list-style-type: none"> <li>Бокс</li> <li>Хүндийн өргөлт</li> <li>Жүдо бөх</li> <li>Жюү Жицү бөх</li> <li>Самбо бөх</li> <li>Пауэрлифтинг</li> <li>Чөлөөт бөх</li> <li>Бүжгийн спорт</li> <li>Спортын гимнастик</li> <li>Туялзуур сэлэм</li> <li>Мөсний шагайн харваа</li> <li>Цана</li> <li>Даам</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Жүдо бөх</li> <li>Мөсний шагайн харваа</li> <li>Тэшүүр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Жүдо бөх</li> <li>Пауэрлифтинг</li> <li>Чөлөөт бөх</li> <li>Уран сайхны гимнастик</li> <li>Бокс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Жүдо бөх</li> <li>Пауэрлифтинг</li> <li>Чөлөөт бөх</li> <li>Туялзуур сэлэм</li> <li>Шагайн харваа</li> <li>Хүндийн өргөлт</li> <li>Самбо бөх</li> <li>Буудлага</li> <li>Даам</li> <li>Шатар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Шагайн харваа</li> <li>Бүжгийн спорт</li> <li>Аэробик</li> <li>Триатлон</li> <li>Го-даам</li> <li>Шатар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөнгөн атлетик</li> <li>Пара хөнгөн атлетик</li> <li>Бүжгийн спорт</li> <li>Үндэсний сур харваа</li> <li>Модон бөмбөг</li> <li>Хонхтой бөмбөг</li> </ul>
VII сар	VIII сар	IX сар	X сар	XI сар	XII сар
<ul style="list-style-type: none"> <li>Үндэсний сур харваа</li> <li>Триатлон</li> <li>Рафтинг</li> <li>Паркоур</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Жүдо бөх</li> <li>Цана</li> <li>Нисэх загварын спорт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бүжгийн спорт</li> <li>Буудлага</li> <li>Нисэх загварын спорт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Буудлага</li> <li>Го-даам</li> <li>Даам</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Гандбол</li> <li>Даам</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Го-даам</li> </ul>



# СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА
2. ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА
3. ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ҮР ДҮН


3



## УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ НИЙТ ЗААЛНЫ ТОО

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй спорт заалны тоо (Улаанбаатар хотод **300** спорт заал үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй спорт заалны **27.6 хувь** нь юм.)

2021 онд Улаанбаатар хотод шинээр ашиглалтад орсон спорт байгууламжууд




Дүүрэг	Спорт ын ордон	Спортын заал	Бэлтгэлийн заал	Усан бассейн	Бусад	Нийт
Багануур	0	1	0	0	0	1
Багахангай	0	0	0	0	0	0
Баянгол	0	0	0	0	0	0
Баянзүрх	0	3	0	0	0	3
Налайх	0	0	0	0	0	0
Чингэлтэй	0	0	0	0	0	0
Сонгинохайрхан	0	2	0	0	0	2
Сүхбаатар	0	0	0	0	0	0
Хан-Уул	1	4	3	1	1	10
<b>Нийт</b>	<b>1</b>	<b>10</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>16</b>
<b>Нийт</b>						<b>16</b>

**ЭДГЭЭР НЬ ШИНЭЭР БАРИГДАХ СПОРТ ЦОГЦОЛБОРЫН ШУУД ӨРСӨЛДӨГЧ БОЛЖ ЧАДАХГҮЙ.**

## ӨРСӨЛДӨГЧИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Дараах спорт байгууламжуудаар тэмцээнд оролцох, бэлтгэл сургуулилт хийх зэрэг шалтгаанаар үйлчлүүлж байсан уу? Хэрэв тийм бол хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?



## ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА

### Үйл ажиллагааны чиглэл

Үйл ажиллагааны чиглэл	Степпе арена	UG арена	Буянт-Ухаа спортын ордон
Шинэ жил хүлээн авалт	Боломжтой	Боломжтой	Боломжтой
Урлагийн тоглолт	Боломжтой	Боломжтой	Боломжтой
Спорт арга хэмжээ	Боломжтой	Боломжтой	Боломжтой
Хурал, семинар, хүлээн авалт	Боломжтой	Боломжтой	Боломжтой
Хурим	Боломжтой	Боломжтой	Боломжтой
Экспо	Боломжтой	Боломжтой	Боломжтой

### Ерөнхий мэдээлэл

Ангилал	Степпе арена	UG арена	Буянт-Ухаа спортын ордон
Хаяг байршил	Хан-Уул дүүрэг, 8-р хороо, Өлзийтийн зам гудамж буюу Шинэ Яармаг хорооллын урд байрлаж байна.	Баянгол дүүргийн гуравдугаар хороо, Үйлдвэрийн төвийн бүс-2, Дундгол гудамжинд байрлаж байна.	Хан-Уул дүүрэг Буянт Ухаа Спортын ордон.
Ажиллах цагийн хуваарь	Дав-Ням 10:00-21:00 /Захиалгат арга хэмжээтэй үед цагийн хуваарьт өөрчлөлт орж болно./	Дав-Ням 10:00-20:00 /Захиалгат арга хэмжээтэй үед цагийн хуваарьт өөрчлөлт орж болно./	БНХАУ-ын буцалтгүй тусламжаар их засвар хийж буй бөгөөд Ордны үйл ажиллагаа бүрэн зогссон болно.
Үйлчилгээний чиглэл	Спортын төрлүүд, соёл урлагийн тоглолт, экспо, хурал зэрэг арга хэмжээг хүссэн шийдлээрээ зохион байгуулах боломжтой.	Урлаг, спортын ямар ч арга хэмжээнд тохирон дэлхийн стандарт хэв маягаа алдахгүйгээр өөрчлөгдөн хувирч зохион байгуулж чадна.	Үндэсний хэмжээний томоохон барилдаан, спортын тэмцээн зохион байгуулах том заалтай. Ихэвчлэн олон хүнийг хамарсан үйл ажиллагааг дагнан явуулдаг.

## ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА

### Зохион байгуулах боломжтой спортын арга хэмжээ

Ангилал	Степпе Арена	UG Арена	Буянт-хаа спортын ордон
Хоккей	+	-	-
Уран гулгалт, чөлөөт гулгалт	+	-	-
Мөсний шагай	+	-	-
Даам, шатар, го	+	+	+
Ширээний теннис	+	+	+
Бадминтон	+	+	+
Сагсан бөмбөг	+	+	+
Волейбол	+	+	+
Спортын гимнастик	+ /бүх тоног төхөөрөмжөө байрлуулаад тэмцээн зохион байгуулахад жижигдэнэ./	+ /бүх тоног төхөөрөмжөө байрлуулаад тэмцээн зохион байгуулахад жижигдэнэ./	+ /бүх тоног төхөөрөмжөө байрлуулаад тэмцээн зохион байгуулахад жижигдэнэ./
Жүдо	+	+	+
Чөлөөт бөх	+ /хүйтэн/	+	+
Таеквондо	+	+	+
Бокс	+	+	+
Хөнгөн атлетик	-	-	-
Хөл бөмбөг	-	-	-
Усан сэлэлт	-	-	-
Хүндийн өргөлт	+ /шалны асуудал/	+ /шалны асуудал/	+ /шалны асуудал/
И Спорт	+ /лед телевиз нэмэлтээр түрээсэлдэг/	+ /лед телевиз нэмэлтээр түрээсэлдэг/	+ /лед телевиз нэмэлтээр түрээсэлдэг/

### Тоног төхөөрөмж болон дотоод өрөөнүүдийн харьцуулалт

Ангилал	Степпе Арена	UG Арена	Буянт-Ухаа спортын ордон
Таазны дэлгэц	+	360 Full HD Led таазны дэлгэц.	-
Суудал	Суудлын тоог хоккейн тэмцээн зохион байгуулагдахад 2600, бусад арга хэмжээнүүдэд 3500 хүртэл нэмэх боломжтой.	3,000 ширхэг эвхэгддэг суудал.	5045 суудал.
Хөгжим, аппаратур	Байгаа.	JBL BRX, Vertec-Line хөгжим аппаратур.	+
Гэрэлтүүлгийн систем	Гэрэлтүүлгийн орчин үеийн тоног төхөөрөмжтэй.	Хамгийн сүүлийн үеийн гэрэлтүүлгийн систем, эффект.	+
Шууд дамжуулалтын цахим ТВ станц	-	+	-
Тамирчдын өрөө	+ /5 өрөөтэй/	+ /5 өрөөтэй/	-
Тамирчдын хувцас солих өрөө	+	+	+
Тамирчдын хувцас солих өрөөнд байрлах ариун цэвэр, усанд орох өрөө	-	+	-
Бариа заслын өрөө	+	+	-
И спортын танхим, тоног төхөөрөмж	-	177 хүний багтаамжтай мэргэжлийн түвшний компьютер тоног төхөөрөмжийг суурилуулсан.	-
Тусгай өрөө	+	+	-
Хурлын танхим	80-100 хүний багтаамжтай	200м.кв, 300м.кв хоёр өрөөтэй мөн нэгтгэж болно.	-
Тамирчдад зориулсан тусгай лифт	-	+	-
Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх өрөө	+	+	-

## ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА

### Нийтийн тээврийн чиглэл

Спорт цогцолбор	Степпе Арена	UG Арена	Буянт-Ухаа спортын ордон
Зорчих автобус	ХО:6 (Түргэний гол эцэс-120 Мянгат)	Ч:61 (Дулааны цахилгаан станц)	Ч:56
	Ч:56 (Архивын ерөнхий газар-120 Мянгат)	Ч:42 (Зайсан-Монголын хюндай киа)	Ч:68
	Ч:68 (Архивын Ерөнхий газар-Нисэхийн шинэ эцэс)	С:68, С:4, С:5	ХО:7, ХО:9, С:4
Хотын төвөөс зорчих хугацаа /автобус/	94 минут	48 минут	84 минут
Хотын төвөөс зорчих хугацаа /машин/	47 минут	24 минут	42 минут

### Авто зогсоол байдаг эсэх

Ангилал	Степпе Арена	UG Арена	Буянт-Ухаа спортын ордон
Авто зогсоол	Энгийн зогсоол, VIP гэсэн 2 зогсоолтой	Гаднаа 700, дотроо 140 машины зогсоолтой	Машин зогсоолтой

### Тасалбар борлуулалтын хэлбэр

Ангилал	Степпе Арена	UG Арена	Буянт-Ухаа спортын ордон
Тасалбар борлуулах хэлбэр	Билетийн касс, ticket.mn, <a href="https://steppearena.mn">https://steppearena.mn</a>	shoppy.mn	ticket.mn

### Түрээсийн үнийн талаарх мэдээлэл

Ангилал	Степпе Арена	UG Арена	Буянт ухаа спортын ордон
Нэг цагийн хөлс	1.5 сая төгрөг	1 сая төгрөг	-
Ажлын өдрийн хөлс	22 сая төгрөг	35 сая төгрөг	2.5 сая төгрөг байсан /хуучин үнэ/
Амралтын өдрийн хөлс	38.5 сая төгрөг	35 сая төгрөг	4.0 сая төгрөг байсан /хуучин үнэ/

## ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА

### Давуу болон сул тал

Спортын цогцолбор	Давуу тал	Сул тал
<b>UG Арена</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Суудал хураагддаг</li> <li>• Хотын төвд байршилтай</li> <li>• Бусад төрлийн худалдаа үйлчилгээтэй /1, 2 дугаар давхар/</li> <li>• Зориулалтын E sport –ийн төвтэй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэ өндөр</li> <li>• Одоогоор цогцолборын үйл ажиллагаа жигдрээгүй, бүрэн нээгдээгүй</li> <li>• Волейболын тэмцээн зохион байгуулах боломжгүй</li> <li>• Заалруу шууд машин орох боломжгүй тул ямар нэг үйл ажиллагаанд зориулж заалыг бэлдэхэд хүндрэлтэй</li> </ul>
<b>Степпе Арена</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Гэрэл, техник тоног төхөөрөмж сайн</li> <li>• Заал руу шууд машин орох боломжтой. Тиймээс ямар нэг үйл ажиллагаанд зориулж заалыг бэлдэхэд хялбар байдаг</li> <li>• Үзэгчдийн суудлыг багасгаж болдог</li> <li>• Өвлийн спортын бүх төрлийн үйл ажиллагаа зохион байгуулах боломжтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Лед дэлгэцгүй. Тиймээс спортын хороод тэмцээний үеэр баннер хэвлүүлэх, гаднаас дэлгэц түрээслэх зэрэг арга хэмжээ авдаг</li> <li>• Байршил хотын төвөөс хол учир зорьж очин тэмцээн үзэх хүн бага байдаг</li> <li>• Өвлийн спортод зориулсан байгууламж тул зарим төрлийн спортын арга хэмжээг олон улсын стандарт шаардлагад нийцсэн байдлаар зохион байгуулах боломжгүй байдаг</li> <li>• Мөсөн гадаргуу дээр спорт үйл ажиллагаа зохион байгуулах шал дэвсдэг</li> <li>• Өндөр үнэтэй</li> <li>• Волейболын тэмцээн зохион байгуулах боломжгүй /волейболын шонгүй/</li> <li>• Худалдаа үйлчилгээ байдаггүй /дэлгүүр, зоогийн газар г.м/</li> <li>• Рестораны хоол өндөр үнэтэй</li> </ul>
<b>Буянт-Ухаа спортын төв ордон</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хамгийн олон хүний суудалтай цогцолбор</li> <li>• Засвар хийгдэж байгаа</li> <li>• Цаашдаа шигшээ багийн бэлтгэл сургуулилын төвтэй хамтран үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж байгаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хэтэрхий том</li> <li>• Урсгал зардал өндөртэй /Жилийн зардал 45 сая төгрөг, орлого 25 сая төгрөг/</li> <li>• Үзэгчдийн суудал өндөрт байрладаг тул тэмцээн хэрхэн өрнөж буйг үзэгч харах, сонсох, мэдрэх боломж багатай байдаг.</li> <li>• Гарах хаалга бүр дээр 00 байдаггүй.</li> <li>• Байгууллагын дотоод менежмент, зохион байгуулалт сул, хэнтэй харьцах нь тодорхойгүй байдаг</li> <li>• Худалдаа үйлчилгээ байдаггүй /дэлгүүр, зоогийн газар г.м/</li> <li>• Заал руу машин орох боломжгүй</li> <li>• Лед дэлгэц, унждаг дэлгэц байхгүй</li> <li>• Байршил хотын төвөөс хол учир зорьж очин тэмцээн үзэх хүн бага байдаг</li> </ul>



## ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГЫГ СУДЛАХ ҮНДЭСЛЭЛ

Шинээр байгуулагдаж буй спорт цогцолборын одоогийн өрсөлдөгчдөөс ялгарах онцлогийг тодорхойлох, үйл ажиллагааны чиглэлийг олон улсын чиг хандлагад нийцсэн байхаар төлөвлөлт хийхийн тулд олон улсын сайн туршлагуудыг судалсан.

Гадаад улсын спорт цогцолборт бэлтгэл, сургуулилт хийхийн давуу болон сул талыг тодруулах

Түүвэр судалгаа болон чанарын судалгаа

Байршлын давуу талыг ашиглан өндрийн бэлтгэлийн төв байгуулах боломжийг тодруулах


Кени улсын Итен хотод байрлах өндрийн бэлтгэлийн төвийн туршлага болон чанарын судалгаа

Спортын клуб, академи байгуулах боломжийн талаар тодруулах


Катар улсын туршлага болон чанарын судалгаа

## ГАДААДАД БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТ ХИЙХИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛЫН ТАЛААР

Гадаад улсад бэлтгэл хийхийн давуу тал



Гадаад улсад бэлтгэл хийхийн сул тал



## ГАДААДАД БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТ ХИЙХИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛЫН ТАЛААР

### Чанарын судалгааны үр дүнгээс

#### Бэлтгэл хийж байсан газар

- АНУ-ын Олимпын хотхон
- ОХУ-ын Сочи Олимпын төв
- Турк улс
- Польш улс
- Өвөр Монголын Өөртөө Засах Орны нийслэл Хөх хот
- Катарын нийслэл Доха хот

**Давуу тал:** Бэлтгэлийн бүхий л үйл ажиллагаа шинжлэх ухаанд суурилсан, тодорхой стандартыг барьсан, төвлөрсөн байдгаараа онцлог байдаг.

- Хооллолт, нэмэлт тэжээл: Томоохон тэмцээний өмнө тамирчид спортын дасгал хөдөлгөөн хийхээс гадна сэтгэл зүйгээ бэлдэж амралт, хооллолтоо зохицуулах нь чухал байдаг байна. Тухайлбал тамирчин тус бүрийн онцлогт тохирсон хооллолт, ус, уураг, эрдэс бодисын зөвлөгөө үйлчилгээ хэрэгтэй байдаг тухай тамирчид дурджээ.
- Амралт: Бэлтгэлийн үед тамирчны бие бүх зүйлд мэдрэмтгий болсон байдаг тул байрлах байрын дулаан, агааржуулалт, амрах, унтах цаг маш чухал байдаг. Гадаад улсад бэлтгэл сургуулилт хийж байхад тамирчид дулаан тохилог байранд байрлахаас гадна бэлтгэлийн хувцсыг нь угааж өрөөний үүдэнд тавих зэрэг үйлчилгээ хамгийн их таалагдсан байна.
- Сэтгэл зүй: Тамирчдын сэтгэл зүйд нөлөө үзүүлдэг хамгийн том хүчин зүйлсийн нэг нь ар гэр, хүүхдүүд байдаг. Гадаадын бэлтгэлийн төвүүдэд тамирчдын гэр бүл, хүүхдүүдийг хамтад нь байрлуулах зэрэг үйлчилгээ байдаг бөгөөд энэ нь тамирчдын сэтгэл зүйн өндөр нөлөө үзүүлдэг тухай тамирчид дурджээ.
- Эмчилгээ үйлчилгээ: Бэлтгэл бүрийн дараа тамирчин бүр их бага хэмжээний бэртэл авсан байдаг бөгөөд энэ үед мөсөөр жин тавих, булчин суллах массаж, бассейн байх нь тамирчдад маш хэрэгтэй байдаг байна. Эдгээр нь дараагийн томоохон бэртлээс урьдчилан сэргийлэх хамгийн сайн арга болдог гэж тамирчид үзжээ.

## ӨНДРИЙН БЭЛТГЭЛИЙН ТӨВ

### Кени улсын Итен хотод байрлах өндрийн бэлтгэлийн төв

- Далайн төвшнөөс дээш **2,400 метрт** байрладаг
- **800 гаруй тамирчин** бэлтгэл сургуулилт хийдэг
- **Жуулчид** энгийн иргэдийн хүлээн авдаг
- Бэлтгэл хийх гэж байгаа тамирчинд хамгийн багадаа 14 хоногийн бэлтгэлийн хөтөлбөр санал болгодог
- **Төлбөр-1,495 евро** (14 хоногийн бэлтгэлийн төлбөр)
- Өөрийн **тариалангийн талбай, фермтэй**
- **Спортын бариа засал, саунтай**
- 400 метрийн урттай гүйлтийн шороон зам болон цаг агаарын ямар ч үед ашиглах боломжтой тартан **гүйлтийн замтай**
- Иж бүрэн **тоноглогдсон биеийн тамирын заалтай**
- 25 метрийн урттай **усан сантай**



## ӨНДРИЙН БЭЛТГЭЛИЙН ТӨВ

### Чанарын судалгааны үр дүнгээс

- Улаанбаатар хотод өндрийн бэлтгэлийн төв байгуулах хангалттай өндөр газар байхгүй гэж тамирчид үзжээ.
- Далайн түвшнээс дээш 2400 м орчим өндөрт бэлтгэлийн төв байгуулбал тамирчид очиж бэлтгэл хийх магадлал нэмэгдэнэ гэж спортын тамирчид үзэж байна.

## СПОРТЫН АКАДЕМИ

2004 онд Катар улс нь өөрийн улсын спортын салбарын хөгжилд анхаарч “Aspire Academy”-ийг үүсгэн байгуулсан. Энэхүү академи нь Катар улсын тамирчдыг бэлтгэх, хөгжүүлэхэд туслахын зэрэгцээ дунд сургуулийн боловсрол олгох спорт академи бөгөөд спортын аваргуудыг багаас нь бэлтгэх зорилготой.

### Боловсролын хөтөлбөр

- Шинжлэх ухаан



- Нийгэм хүмүүнлэгийн шинжлэх ухаан



### Спортын тамирчин бэлдэх хөтөлбөр

- Туялзуур сэлэм
- Сквош теннис
- Ширээний теннис
- Хөнгөн атлетикийн төрлүүд



## СПОРТЫН АКАДЕМИ

### Хөл бөмбөгийн тамирчин бэлдэх хөтөлбөр

“Aspire Academy’s Football Performance and Science”

Тамирчин тус бүрийн биеийн хөгжилд нь тохирсон дасгал сургуулилтыг хийлгэж, сэтгэл зүйд нь анхаарч орчин үеийн шинжлэх ухааны аргад суурилан залуу тамирчдын хөгжүүлэх зорилт тавин ажилладаг.

### Спортын шинжлэх ухааны баг

- Спортын шинжлэх ухаанч
- Хүчний бэлтгэлийн дасгалжуулагч
- Спортын сэтгэл зүйч
- Дасгалын зөвлөх
- Спортын шим судлаач
- Био механист
- Физик эмчилгээний эмч





## СПОРТЫН АКАДЕМИ


### Чанарын судалгааны үр дүнгээс

- Бүх спортод залгамж тамирчдын бэлдэх асуудал тулгардаг.
- Монгол Улсад мэргэжлийн спортын сургуулиуд байдаг ч спортын мэргэжлийн тамирчин, залгамж халаа бэлдэхэд учир дутагдалтай байна.
- Тиймээс хэрэв спортын мэргэжлийн тамирчин бэлдэх сургууль байгуулбал суралцагсдын хооллолт, дасгал сургуулилтын хуваарилалт зэрэгт шинжлэх ухаанчаар хандахаас гадна тодорхой нэг спорт дээр илүүтэй төвлөрөн үйл ажиллагаа явуулах нь илүү үр дүнтэй байх талаар спортын мэргэжлийн байгууллагууд дурджээ.




## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


### Хүйс




### Оролцогчийн төрөл



### Нас, *mean=29*



### Тухайн спортоор хичээллэж/ажиллаж буй жил, *mean=10*




### Аль спортын төлөөлөл болох?




## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТАА ХЭРХЭН ХИЙДЭГ ВЭ?

Тогтмол бэлтгэл сургуулилтаа хийдэг үү?




Тогтмол бэлтгэл сургуулилтаа хийдэг үү?, спортын төрлөөр




## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТАА ХЭРХЭН ХИЙДЭГ ВЭ?


Бэлтгэл сургуулилтаа идэвхтэй хийдэг сарууд



7 хоногт хэдэн удаа бэлтгэл, сургуулилт хийдэг вэ?




Нэг удаагийн бэлтгэл, сургуулилтад зарцуулж буй хугацаа, *цагаар*



*Нэг тамирчин дунджаар долоо хоногт 6 удаа бэлтгэл, сургуулилт хийдэг, нэг удаа хийх бэлтгэл, сургуулилтаа 2.8 цаг зарцуулдаг бол жилд 37 өдрийг бэлтгэл сургуулилтаа зарцуулдаг байна.*

## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТАА ХААНА ХИЙДЭГ ВЭ?


Бэлтгэл сургуулилтаа ихэвчлэн хаана хийдэг вэ?



- Тогтмол нэг газар буюу гэрээлсэн спорт зааландаа
- Тогтмол бэлтгэл, сургуулилт хийдэг газар байдаггүй

Бэлтгэл сургуулилтаа тогтмол нэг газартаа хийдэггүй гэж хариулсан оролцогчдоос учир шалтгааныг тодруулахад стандартын наад захын шаардлага хангасан бэлтгэл хийх газар ховор байдаг гэсэн хариултыг өгч байсан. *Тухайлбал агааржуулалт, цэвэрлэгээ үйлчилгээ гэх мэт.*

Бэлтгэл сургуулилтаа ихэвчлэн хаана хийдэг вэ?, *спортын төрлөөр*



- Тогтмол нэг газар буюу гэрээлсэн спорт зааландаа
- Тогтмол бэлтгэл, сургуулилт хийдэг газар байдаггүй

## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТАА ХААНА ХИЙДЭГ ВЭ?

Бэлтгэл сургуулилтаа ихэвчлэн хаана хийдэг вэ?, *байршлаар*



### Хувийн клубүүд


- Ширэн бээлий
- Хувийн бэлтгэлийн байр
- Талын бүргэд клуб
- Стар фитнес
- Цагаанбаатар академи
- Оч ширээний теннисийн клуб
- Орчлон усан спортын клуб
- Мандал оюут дэвжээ
- Голден жим
- Гокү жим
- ГАТУ
- Гаруда төв
- Бага тэнгэрийн ам хөл бөмбөгийн талбай, Дэрэн клуб
- S клуб
- Radiant бокс клуб
- Boot camp багийн бэлтгэлийн газар
- ВВ жюү жицү академи

### Түрээсийн заал, талбай

- Ягаан заал
- Элит спорт заал
- Хүмүүн цогцолбор
- Хурд спорт заал
- Хил хамгаалах ерөнхий газар
- УБ Их сургууль заал
- Сургуулиудын болон хувийн зааланд
- МУИС-ийн спорт заал
- МУБИС-ийн тамирын заал
- МУ-ын биеийн тамирын дээд сургууль
- Мөнхийн үсгийн спорт зааланд
- Дунд сургуулиудын зааланд

## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТАА ХААНА ХИЙДЭГ ВЭ?

Бэлтгэл сургуулилтаа ихэвчлэн хаана хийдэг вэ?, *спортын төрлөөр*



■ Хувийн клубүүдэд 
 ■ Түрээсийн заал, талбай 
 ■ Спорт цогцолбор, байгууламж 
 ■ Спортын хороод болон дүүргийн спортын төвүүд 
 ■ Спортын төв ордон

## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТАА ХААНА ХИЙДЭГ ВЭ?


### Чанарын судалгааны үр дүнгээс

- Тамирчид хувийн заал, клубүүдэд ихэвчлэн бэлтгэл сургуулилтаа хангадаг.
- Тамирчдын хувьд бэлтгэл хийх газраа сонгоход байршил, стандартын шаардлага хангасан заал, бэлтгэлийн тоног төхөөрөмж, дасгалжуулагч зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг.
- Бэлтгэл сургуулилт хийж буй газруудын хувьд зориулалтын тоног төхөөрөмж, заалтай газрууд ихэвчлэн тохилог орчин нөхцөлгүй байдаг бол тохилог орчин нөхцөлтэй газар мэргэжлийн тоног төхөөрөмжгүй байх асуудал үүсдэг байна.
- Тиймээс мэргэжлийн тамирчдад зориулсан зориулалтын бэлтгэлийн заал, тоног төхөөрөмжтэй, тав тухтай орчин хэрэгцээтэй байна.




## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТ ХИЙДЭГ ГАЗАРТАА ХЭР СЭТГЭЛ ХАНАМЖТАЙ БАЙДАГ ВЭ?

Ерөнхий үнэлгээ, оноогоор



Судалгаанд оролцогчид одоогийн бэлтгэл, сургуулилт хийж буй газрынхаа орчин нөхцөлд сэтгэл ханамж тааруу байгаа буюу сэтгэл ханамжийн үнэлгээ **2.99** байна. Энэ нь бэлтгэл, сургуулилт хийх газрын орчин нөхцөлийг бүхэлд нь сайжруулах хэрэгцээ, шаардлагатай байгааг илэрхийлсэн үр дүн юм. Ач холбогдлын түвшин 4.44 байгаа нь одоогийн хувийн клуб, спорт заалнууд судалгаанд оролцогчдын хүлээлтэд нийцсэн үйлчилгээг огт хүргэж чадахгүй байна.


Ерөнхий үнэлгээг оролцогчдын төрлөөр харуулах



Сэтгэл ханамжийн үнэлгээг оролцогчдын төрлөөр ангилан харвал тамирчдын бэлтгэл, сургуулилт хийдэг газрынхаа орчин нөхцөлд өгсөн үнэлгээ 2.98 буюу дундаж үнэлгээнээс доогуур түвшин байна. Дасгалжуулагчдын үнэлгээ тамирчдынхаас илүү байлаа.


## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТ ХИЙДЭГ ГАЗАРТАА ХЭР СЭТГЭЛ ХАНАМЖТАЙ БАЙДАГ ВЭ?

Одоогийн бэлтгэл, сургуулилт хийдэг газартаа өгч буй сэтгэл ханамжийн үнэлгээ, *оноогоор*




## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТ ХИЙДЭГ ГАЗАРТАА ХЭР СЭТГЭЛ ХАНАМЖТАЙ БАЙДАГ ВЭ?

Одоогийн бэлтгэл, сургуулилт хийдэг газартаа өгч буй сэтгэл ханамжийн үнэлгээ, *оролцогчдын төрлөөр*




## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТ ХИЙДЭГ ГАЗАРТАА ХЭР СЭТГЭЛ ХАНАМЖТАЙ БАЙДАГ ВЭ?

Одоогийн бэлтгэл, сургуулилт хийдэг газартаа өгч буй сэтгэл ханамжийн үнэлгээ, *оноогоор, бэлтгэлийн байраар*




Одоогийн байршилд хэн илүү сэтгэл ханамжгүй байгаа талаар оруулах



## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТ ХИЙДЭГ ГАЗАРТАА ХЭР СЭТГЭЛ ХАНАМЖТАЙ БАЙДАГ ВЭ?

Одоогийн бэлтгэл, сургуулилт хийдэг газартаа өгч буй сэтгэл ханамжийн үнэлгээ, *оноогоор, спортын төрлөөр*



## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТ ХИЙДЭГ ГАЗАРТАА ХЭР СЭТГЭЛ ХАНАМЖТАЙ БАЙДАГ ВЭ?

Аль спортын тамирчид юунд илүү сэтгэл ханамжгүй байгаа талаар?

Нэгж үзүүлэлтүүд	Сэтгэл ханамжгүй байдал																
	Үндэсний бөх	Жүдо бөх	Самбо бөх	Ширээний теннис	Чөлөөт бөх	Жюу-жицу бөх	Холимог тулаан	Сагсан бөмбөг	Волейбол	Усан спорт	Бодибилдинг	Хөнгөн атлетик	Гимнастик	Хүндийн өргөлт	Хөл бөмбөг	Бокс	E-Sport
Спортын заал	4.0	4.1	3.6	3.7	2.9	4.5	3.8	3.7	3.3	3.3	4.4	2.8	3.5	4.4	4.0	4.2	3.8
Бэлтгэлийн заал	4.3	4.2	3.3	3.6	2.9	4.1	4.3	3.7	3.6	3.3	4.2	3.0	3.1	4.6	3.9	4.3	4.0
Фитнесийн иж бүрэн тоног төхөөрөмж бүхий заал	4.3	4.2	3.0	2.5	3.0	3.7	3.4	3.9	3.6	4.0	4.6	4.4	2.5	3.6	4.5	3.5	3.5
Хувцас солих өрөө, душ	3.3	3.2	2.3	2.5	2.1	3.0	3.7	3.0	3.3	2.8	4.6	4.0	3.0	2.8	3.0	3.4	3.5
Саун	3.6	2.6	2.6	2.5	2.4	2.0	3.2	2.5	2.0	5.0	4.5	2.5	1.0	2.3	3.0	3.0	3.0
Ресторан, хоолны газар, Амрах байр, буудал	2.4	2.4	2.5	4.0	2.0	2.8	2.6	2.8	2.7	3.3	4.0	3.8	2.0	2.9	4.5	2.3	2.0
Гадна бэлтгэлийн талбай	1.9	2.9	2.3	3.8	2.3	3.3	2.6	2.8	2.6	3.7	4.3	3.0	5.0	2.4	5.0	2.3	4.3
Спортын тоног төхөөрөмж	1.3	2.4	2.1	3.0	2.3	2.8	3.6	2.0	2.9	3.7	4.0	3.4	3.0	1.7	3.5	4.3	3.0
Агааржуулалт	3.8	3.5	2.6	4.0	2.8	3.4	3.9	4.0	3.0	3.8	4.6	4.0	3.7	2.7	3.7	3.7	3.5
Мөсний машин	3.8	3.2	2.9	3.1	3.1	3.6	3.6	3.3	3.1	3.4	4.2	3.4	2.3	2.6	3.4	3.2	3.8
Эмнэлгийн үйлчилгээ	1.2	2.7	1.6	2.0	1.3	2.0	2.0	1.0	3.0	1.0	4.0	1.5	1.0	1.6	5.0	1.0	3.0
Хувцас угаалга, цэвэрлэгээ	2.3	3.0	3.0	3.2	2.7	2.5	2.4	3.0	2.6	3.5	2.7	2.8	3.3	3.3	3.5	3.2	2.3
Автомашин зогсоол	1.0	2.7	2.1	2.0	1.5	1.8	2.4	2.5	2.8	2.5	4.0	2.3	3.0	1.0	2.6	2.0	3.5
Харуул хамгаалалт	2.3	2.7	2.5	2.5	1.8	3.3	1.0	2.4	2.8	2.8	4.2	2.0	3.8	1.7	3.4	3.3	2.2
Гэрэлтүүлэг	3.0	2.8	3.7	3.4	2.8	3.4	3.2	3.9	3.6	3.8	4.4	3.4	1.8	4.1	4.2	3.8	3.6
Спортын тамирчид	3.6	3.7	3.3	3.4	2.6	3.9	3.9	3.6	3.4	4.4	4.4	3.3	3.5	4.0	4.0	4.0	3.8
Спортын тамирчид	2.1	3.2	2.3	3.8	2.3	1.8	1.5	2.5	3.0	2.0	4.3	2.6	4.5	1.3	2.7	4.0	2.7
Хоол зүйч	1.3	2.9	1.8	3.5	1.6	3.6	3.8	3.3	2.8	4.7	4.3	2.0	5.0	1.8	2.7	4.3	3.0
Сэтгэл зүйч	1.6	3.4	2.0	2.3	1.7	3.0	2.0	4.3	3.0	4.0	3.0	2.0	3.5	1.5	3.5	4.7	3.0
Спортын бариа засалч	2.0	4.6	2.3	2.8	2.1	3.2	2.3	3.8	3.0	3.0	3.5	2.0	3.0	1.7	3.8	2.8	2.0

## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТ ХИЙДЭГ ГАЗАРТАА ХЭР СЭТГЭЛ ХАНАМЖТАЙ БАЙДАГ ВЭ?


### Чанарын судалгааны үр дүнгээс

- Тамирчдын нэгдсэн бэлтгэл хийдэг газруудад төвлөрсөн, мэргэжлийн үйлчилгээ байдаггүй.
- Тамирчид ихэвчлэн нэгдсэн бэлтгэлээ хүүхдийн зуслан, амралтын газруудад хийдэг.
- Тиймээс байрлаж буй байр хүйтэн, зориулалтын тоног төхөөрөмжгүй байх, хоолны хувьд нүүрс ус ихтэй, шингэц удаан байх зэрэг асуудал үүсдэг.
- Мөн бэлтгэлийн үеийн амралт чухалд тооцогдох тул хувцас угаах, иллэг, массаж хийлгэх орчин нөхцөл хэрэгтэй байдаг байна.
- Бүх бэлтгэлийн дараа тамирчид их, бага хэмжээгээр бэртдэг бөгөөд бэлтгэлийн дараа хэрэглэх мөс огт байдаггүй тухай тамирчид дурджээ.




## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТДАА ЗАРЦУУЛЖ БҮЙ МӨНГӨН ДҮН ХЭДЭН ТӨГРӨГ ВЭ?

Бэлтгэл, сургуулилтдаа зарцуулж буй мөнгөн дүн, *мянган төгрөгөөр*



Бэлтгэл, сургуулилтдаа зарцуулж буй мөнгөн дүнгийн хувь хэмжээ, *спортын төрлөөр*




## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТТАЙ ХОЛБООТОЙ АВАХЫГ ХҮСЭЖ БУЙ ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫН ТАЛААР

Бэлтгэл, сургуулилттай холбоотой хүчин зүйлсэд хөнгөлөлт, урамшуулал авах бол чухам ямар төрлийн хөнгөлөлт, урамшуулал авах хүсэлтэй байна вэ?




Хөнгөлөлт, урамшуулал, *оролцогчдын төрлөөр*



## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТАЙ ХОЛБООТОЙ АВАХЫГ ХҮСЭЖ БУЙ ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫН ТАЛААР

Хөнгөлөлт, урамшуулал, *спортын төрлөөр*




## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТТАЙ ХОЛБООТОЙ АВАХЫГ ХҮСЭЖ БУЙ ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫН ТАЛААР

### Чанарын судалгааны үр дүнгээс

- Спортын хороодын хувьд заалны түрээсийн хөнгөлөлт хамгийн хэрэгцээтэй байна.
- Хамтын ажиллагаа илүү сайн, урт хугацаанд байдаг спорт хороодод тэмцээн зохион байгуулах заалны түрээснээс хөнгөлөх хэрэгцээ хамгийн их байна.
- Тамирчдын хувьд бэлтгэл сургуулилт урт хугацаанд хийхэд дараа дараагийн саруудад хөнгөлөлттэй бэлтгэл хийх боломжийг бий болгох, тухайн төвд үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний төвүүдээр хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэх хэрэгцээ байна.

## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТАА ХЭВИЙН ҮРГЭЛЖЛҮҮЛЭХЭД ЯМАР НЭГЭН ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ ТУЛГАРДАГ УУ?

Бэлтгэл, сургуулилтаа хэвийн үргэлжлүүлэхэд ямар хүндрэл, бэрхшээл тулгардаг уу?




Бэлтгэл, сургуулилтаа хэвийн үргэлжлүүлэхэд ямар хүндрэл, бэрхшээл тулгардаг вэ?




## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТАА ХЭВИЙН ҮРГЭЛЖЛҮҮЛЭХЭД ЯМАР НЭГЭН ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ ТУЛГАРДАГ УУ?

Бэлтгэл, сургуулилтаа хэвийн үргэлжлүүлэхэд ямар хүндрэл, бэрхшээл тулгардаг вэ? *оролцогчдын төрлөөр*



## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТАА ХЭВИЙН ҮРГЭЛЖЛҮҮЛЭХЭД ЯМАР НЭГЭН ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ ТУЛГАРДАГ УУ?

Бэлтгэл, сургуулилтаа хэвийн үргэлжлүүлэхэд ямар хүндрэл, бэрхшээл тулгардаг вэ? *спортын төрлөөр*



- Санхүүгийн асуудал
- Түгжрэл
- Дасгалжуулагч
- Сэтгэл зүйн асуудал

- Багийн гишүүд
- Уураг, витамин
- Бэлтгэлийн газрын ариун цэвэр
- Цаг агаар/өвөл

- Бэртэл гэмтэл, эрүүл мэндийн асуудал
- Бэлтгэлийн нөхцөл, орчин
- Ажил, хияээл, ар гэрийн асуудал




## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТАА ХЭВИЙН ҮРГЭЛЖЛҮҮЛЭХЭД ЯМАР НЭГЭН ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ ТУЛГАРДАГ УУ?

### Чанарын судалгааны үр дүнгээс

- Волейболын мэргэжлийн байгууллагад бэлтгэл хийх газарт зориулалтын буу, бэлтгэлийн өндөрлөг суурь хамгийн хэрэгцээтэй байдаг бол тэмцээн уралдаан зохион байгуулахад шалнаас доош 50 орчим см гүнд ухсан шон байрлуулах нүх хэрэгцээтэй байдаг байна. Түүнчлэн улсын аварга шалгаруулах тэмцээний үеэр маш олон /+1000/ тамирчин хөдөө орон нутгаас оролцог тул байрлах газар, тэмцээн зохион байгуулах заал Улаанбаатар хотод хүрэлцээгүй, төвлөрөлгүй байдаг учраас ихэвчлэн хөдөө орон нутагт зохион байгуулагддаг байна.
- Хүндийн өргөлтийн тамирчдын хувьд бэлтгэл сургуулилт хийх, тэмцээн уралдаан зохион байгуулах зориулалтын шал бүхий заалны хэрэгцээ хамгийн их байна.
- Хөнгөн атлетикийн тамирчдын хувьд тэмцээн уралдаан зохион байгуулах зориулалтын гүйлтийн талбай, өвлийн бэлтгэл хийх газар хамгийн хэрэгцээтэй байна.
- Спортын гимнастикийн тамирчдын хувьд тэмцээн зохион байгуулах зориулалтын том заал хамгийн хэрэгцээтэй байна.
- Усан спортын тамирчдын хувьд тэмцээн уралдаан зохион байгуулах 50 метрийн урттай бассейн болон үсрэлтийн тавцан, зориулалтын хүчний бэлтгэл хийх хэрэглэгдэхүүнүүд хэрэгцээтэй байна.


## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТ ХИЙХ ГАЗРУУДААС ЦААШИД АВАХЫГ ХҮСЭЖ БУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Таны зүгээс спорт байгууламжуудын үйл ажиллагаа болон үйлчилгээ үзүүлэх байдлыг цаашид хэрхэн сайжруулалт, шинэчлэл хийгээсэй гэж хүсэж байна вэ?



## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТ ХИЙХ ГАЗРУУДААС ЦААШИД АВАХЫГ ХҮСЭЖ БҮЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Бэлтгэл, сургуулилт хийх газруудаас цаашид авахыг хүсэж буй үйлчилгээ, *оролцогчдын төрлөөр*



## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТ ХИЙХ ГАЗРУУДААС ЦААШИД АВАХЫГ ХҮСЭЖ БУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Таны зүгээс спорт байгууламжуудын үйл ажиллагаа болон үйлчилгээ үзүүлэх байдлыг цаашид хэрхэн сайжруулалт, шинэчлэл хийгээсэй гэж хүсэж байна вэ? **спортын төрлөөр**

Төрөл	Үндэсний бөх	Жүдо бөх	Самбо бөх	Ширээн ий теннис	Чөлөөт бөх	Жю-жицу бөх	Холимог тулаан	Сагсан бөмбөг	Волейбол	Усан спорт	Бодибилдинг	Хөнгөн атлетик	Гимнастик	Хүндийн өргөлт	Хөл бөмбөг	Бокс	E-Sport
Спортын заал	6.3%	2.9%	12.1%	5.7%	13.5%	7.5%	14.3%	16.1%	11.8%	12.0%	0.0%	8.6%	5.7%	8.8%	8.6%	6.9%	4.0%
Бэлтгэлийн заал	9.4%	14.7%	15.2%	17.1%	13.5%	10.0%	14.3%	3.2%	14.7%	12.0%	11.8%	14.3%	17.1%	11.8%	17.1%	3.4%	12.0%
Фитнесийн иж бүрэн тоног төхөөрөмж бүхий заал	9.4%	0.0%	6.1%	0.0%	10.8%	0.0%	2.9%	9.7%	0.0%	4.0%	17.6%	0.0%	2.9%	2.9%	5.7%	3.4%	8.0%
Хувцас солих өрөө, душ	6.3%	5.9%	3.0%	2.9%	5.4%	7.5%	0.0%	9.7%	5.9%	4.0%	5.9%	0.0%	0.0%	8.8%	0.0%	6.9%	4.0%
Саун	3.1%	2.9%	0.0%	2.9%	2.7%	0.0%	0.0%	3.2%	0.0%	0.0%	0.0%	0.0%	8.6%	14.7%	0.0%	6.9%	0.0%
Ресторан, хоолны газар	3.1%	2.9%	3.0%	2.9%	2.7%	2.5%	2.9%	6.5%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	5.9%	0.0%	0.0%	8.0%
Амрах байр, буудал	6.3%	11.8%	12.1%	2.9%	8.1%	12.5%	5.7%	9.7%	5.9%	8.0%	5.9%	8.6%	2.9%	5.9%	5.7%	10.3%	12.0%
Гадна бэлтгэлийн талбай	0.0%	0.0%	3.0%	8.6%	0.0%	2.5%	2.9%	0.0%	2.9%	0.0%	0.0%	20.0%	0.0%	0.0%	8.6%	3.4%	0.0%
Спортын тоног төхөөрөмж	12.5%	11.8%	0.0%	5.7%	5.4%	2.5%	5.7%	3.2%	11.8%	0.0%	11.8%	0.0%	5.7%	8.8%	5.7%	10.3%	8.0%
Агааржуулалт	3.1%	0.0%	0.0%	8.6%	8.1%	10.0%	5.7%	6.5%	11.8%	4.0%	0.0%	0.0%	5.7%	0.0%	0.0%	3.4%	8.0%
Мөсний машин	6.3%	8.8%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Эмнэлгийн үйлчилгээ	9.4%	11.8%	12.1%	5.7%	8.1%	5.0%	5.7%	6.5%	2.9%	4.0%	5.9%	5.7%	2.9%	8.8%	5.7%	3.4%	8.0%
Хувцас угаалга, цэвэрлэгээ	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	2.5%	0.0%	0.0%	0.0%	4.0%	5.9%	0.0%	0.0%	0.0%	0.0%	3.4%	0.0%
Автомашин зогсоол	0.0%	2.9%	0.0%	5.7%	0.0%	5.0%	5.7%	6.5%	2.9%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	2.9%	0.0%	0.0%
Харуул хамгаалалт	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	3.2%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Гэрэлтүүлэг	0.0%	0.0%	0.0%	5.7%	0.0%	0.0%	0.0%	3.2%	2.9%	0.0%	0.0%	0.0%	0.0%	2.9%	0.0%	6.9%	4.0%
Спорт хоолны газар	0.0%	2.9%	3.0%	2.9%	5.4%	5.0%	8.6%	3.2%	2.9%	4.0%	5.9%	5.7%	5.7%	0.0%	5.7%	3.4%	4.0%
Хоол зүйч	3.1%	0.0%	9.1%	11.4%	5.4%	7.5%	8.6%	0.0%	5.9%	16.0%	11.8%	5.7%	8.6%	2.9%	17.1%	10.3%	4.0%
Сэтгэл зүйч	12.5%	11.8%	9.1%	8.6%	2.7%	10.0%	11.4%	3.2%	8.8%	12.0%	11.8%	11.4%	14.3%	2.9%	5.7%	10.3%	8.0%
Спортын бариа засалч	9.4%	8.8%	12.1%	2.9%	8.1%	10.0%	5.7%	6.5%	8.8%	16.0%	5.9%	20.0%	20.0%	14.7%	11.4%	6.9%	8.0%

## БЭЛТГЭЛ, СУРГУУЛИЛТ ХИЙХ ГАЗРУУДААС ЦААШИД АВАХЫГ ХҮСЭЖ БУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

### Чанарын судалгааны үр дүнгээс

#### Бэлтгэл сургуулилтын үед авахыг хүсэж буй үйлчилгээ

- Бэлтгэл хийх үед байрлах байр
- Спортын төрөл тус бүрд зориулсан техник хэрэгсэл
- Гүйх зам талбай
- Бассейн
- Өвлийн бэлтгэлийн манеж
- Хувцас угаах үйлчилгээ
- Зориулалтын заал, тоног төхөөрөмж
- Спортын мэргэжлийн тамирчдад зориулсан хоол
- Булчин сүллэх, нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээ /мөсний машин/ г.м

#### Тэмцээн уралдааны үед авахыг хүсэж буй үйлчилгээ

- Тэмцээнд оролцож буй тамирчид байрлах газар
- Спортын болон бусад төрлийн хоол, зоогийн газар, рестораны үйлчилгээ
- Хувцас солих өрөө
- Худалгаа үйлчилгээ /хүнсний дэлгүүр, спорт барааны дэлгүүр г.м/
- Лед, унждаг дэлгэц
- Шилэн кабель
- Гэрэлтүүлэг г.м



# ДҮГНЭЛТ

4

## Салбарын өнөөгийн байдал

- Монгол Улсын спортын салбарт баримталж буй хууль, эрх зүйн баримт бичгүүд харьцангуй боловсронгуй болжээ. Өөрөөр хэлбэл салбарт үйл ажиллагаа эрхлэхэд төрийн зүгээс ирэх дарамт шахалт бага, таатай орчинтой байна.
- Биеийн тамир, спортын улсын хорооны мэдээлснээр Монгол Улсын хэмжээнд 22 спортын мэргэжлийн холбоо байгаа ба хувийн байгууллагууд ч мөн идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж спортын салбарт үнэтэй хувь нэмэр оруулж байна. Судалгааны баг спортын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай уулзалт, ярилцлага хийх үеэр шинээр баригдаж буй спортын цогцолборын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах сонирхолтой байгаа гэдгээ илэрхийлж байв.





### Салбарын өнөөгийн байдал

- Монгол Улсад спортын төрлөөр хичээллэдэг нийт тамирчдын 80 орчим хувь нь Улаанбаатар хотод бэлтгэл, сургуулилтаа хийдэг. Тамирчдын тал нь буюу 50 орчим хувь нь спорт тоглоом болох сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөг, гольф, талбайн теннис, ширээний теннисээр хичээллэдэг байлаа.
- Спортын тамирчид нэг жилийн хугацаанд 342.7 тэрбум төгрөгийг бэлтгэл, сургуулилт хийх байрандаа зарцуулдаг болох нь энэ чиглэлд үйл ажиллагаагаа чиглүүлэх нь зах зээлийн хувьд боломж байгааг илэрхийлж байна.





## Өрсөлдөгчийн судалгаа


- Улаанбаатар хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 300 заал байгаа бөгөөд эдгээрийг шинээр байгуулагдах спорт цогцолборын шууд өрсөлдөгч болохгүй гэж үзэж байна.
- Харин судалгаанд оролцогчдоос Монгол Улсын хэмжээд үйл ажиллагаа явуулж буй томоохон спортын байгууламжаас үйлчилгээ авч байсан эсэх, хэрэв тийм бол хэр сэтгэл ханамжтай байгааг тодруулахад UG arena, Степ арена, Буянт ухаа спорт цогцолборт өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ дээгүүр байлаа. Иймээс тухайн байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээ болоод судалгааны үр дүнд үндэслэн өрсөлдөгчийн судалгааг хийсэн.



## Өрсөлдөгчийн судалгаа


Судалгааны үр дүнгээс үзэхэд бидний шинээр байгуулах гэж буй спортын цогцолбор нь бусад өрсөлдөгчдөөс илт давуу үзүүлэлтүүдийнхээ онцлогийг шингээсэн үйл ажиллагаа эрхлэх нь хамгийн тохиромжтой юм. Өөрөөр хэлбэл бусад өрсөлдөгчдөд байхгүй дараах

1. Дэлхийд шалгарсан шилдэг агаарын эко технологиор тоноглогдсон 120x60 харьцаатай, 7200м<sup>2</sup> талбайтай, 1200 хүний суудалтай, 50 м-ийн урт, 1,5 м-ийн гүн , 10 эгнээ замтай **усан спортын ордон**
2. Бүрэн автомат усалгааны системээр тоноглогдсон 300 LUX хүчин чадалтай гэрэлтүүлэгч буюу прожектортой **хөл бөмбөгийн талбай**
3. **Тамирчид байрлах буудал**
4. Гадна ногоон байгууламжийн тохижилт
5. Далайн түвшнээс 1800 метрийн өндөрт байрлах байршлын давуу тал зэрэг



## Олон улсын туршлага

Гадны улс оронд бэлтгэл, сургуулилт хийж байсан оролцогчдын туршлагаас үзэхэд тухайн очсон спорт цогцолбор нь орчин нөхцөл сайтай, бүх үйлчилгээг нэг дор багтаасан цогц үйл ажиллагаа явуулдаг нь хамгийн том давуу тал гэж үзсэн байна. Үүнээс үзэхэд бид тамирчдыг байршуулах буудалтай гэсэн давуу талаа ашиглавал тамирчдыг байрлуулах бүрэн боломжтой.






### Олон улсын туршлага

Өндрийн бэлтгэлийн төв байгуулах боломжтой хэдий ч энэ төрөл нь Монгол орны эрс тэс уур амьсгалд тохиромжгүй, улирлын чанартай явагдах тул үйл ажиллагааны үндсэн чиглэл болж чадахгүй гэж үзэж байна.

Мөн спортын клуб/академи байгуулах боломжтой хэдий ч урт хугацаанд үр ашгаа өгөх тул үйл ажиллагааны үндсэн чиглэл болж чадахгүй гэж үзэж байна. Харин энэ ажлыг урт хугацааны төлөвлөлтөд оруулах нь тохиромжтой.



## Түүвэр судалгааны үр дүн

- Судалгаанд оролцогчдын 21.1 хувь нь эмэгтэй, 78.9 хувь нь эрэгтэй оролцогчид байсан. Дасгалжуулагч, тамирчдыг тэнцүү тоогоор хамруулахыг зорьсон бөгөөд 32.5 хувь нь дасгалжуулагч байна.
- Судалгаанд оролцогчдын тухайн спортоор хичээллэсэн жил дунджаар 10 байсан бол дундаж нас 29 байв. Өөрөөр хэлбэл энэхүү судалгаанд харьцангуй туршлагатай, шинэ үеийн залуучууд хамрагдсан болох нь харагдаж байна.
- Судалгаанд 17 төрлийн спортын тамирчин дасгалжуулагчид хамрагдсан бөгөөд сагсан бөмбөг, усан спорт, хөл бөмбөг, хүндийн өргөлт, ширээний теннис, чөлөөт бөхийн тамирчдаас бусад нь тогтмол бэлтгэл сургуулилтаа жилийн турш хийдэг гэж хариулжээ.





### Түүвэр судалгааны үр дүн

- Тамирчдын бэлтгэл, сургууилт хийх хугацаа 3-6 болон 8-10 дугаар сард идэвхэждэг байна. Нэг тамирчин дунджаар долоо хоногт 6 удаа бэлтгэл, сургууилт хийдэг, нэг удаа хийх бэлтгэл, сургууилтдаа 2.8 цаг зарцуулдаг бол жилд 37 өдрийг бэлтгэл сургууилтдаа зарцуулдаг байна.
- Судалгаанд оролцогчдын 31.7 хувь нь хувийн клубүүдэд, 30.1 хувь нь түрээсийн зааланд, 21.1 хувь нь спортын төв ордонд, 8.9 хувь нь спортын хороодод, 8.1 хувь нь спортын цогцолбор байгууламжид бэлтгэл, сургууилтаа хийдэг гэв. Гэсэн хэдий ч усан спорт, сагсан бөмбөөг, хөл бөмбөг, и спорт, чөлөөт бөх, волейбол, хөнгөн атлетикийн тамирчдад тогтмол бэлтгэл, сургууилт хийх заал, талбай хомс байдаг ажээ.





### Түүвэр судалгааны үр дүн

Дараах спортын төрлүүд нь тогтмол бэлтгэл, сургуулилт хийх газар байдаггүй тул энэ төрлийн спорт хороодтой хамгийн түрүүнд хамтын ажиллагаа тогтоох нь зүйтэй.

1. Усан спорт
2. Сагсан бөмбөг
3. И спорт
4. Хөнгөн атлетик
5. Хөл бөмбөг
6. Чөлөөт бөх
7. Волейбол
8. Үндэсний бөх
9. Жюү-жицу бөх

Тамирчид ихэвчлэн хувийн клуб, түрээсийн зааланд бэлтгэл сургуулилтаа хийдэг бөгөөд энэ нь тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадахааргүй орчин нөхцөлтэй байв.

## Түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд оролцогчид одоогийн бэлтгэл, сургуулилтаа хийж буй газартаа маш их сэтгэл ханамжгүй байгаа бөгөөд тэдний хүлээлтэд хүрсэн үйлчилгээг үзүүлж чаддаггүй болохыг сэтгэл ханамжийн үнэлгээ 2.99, ач холбогдол 4.44 байгаагаас харж болохоор байна. Сэтгэл ханамжийг үнэлүүлсэн ихэнх үзүүлэлтүүдэд сэтгэл ханамж маш бага түвшинд байсан. Түүнчлэн спортын төв ордонд болон спортын цогцолбор байгууламжид бэлтгэл, сургуулилт хийдэг тамирчид, дасгалжуулагчид илүү сэтгэл ханамж бага байна.

Сэтгэл ханамжийн үнэлгээг оролцогчдын төрлөөр ангилан харвал тамирчдын бэлтгэл, сургуулилт хийдэг газрынхаа орчин нөхцөлд өгсөн үнэлгээ 2.98 буюу дундаж үнэлгээнээс доогуур түвшин байна. Дасгалжуулагчдын үнэлгээ тамирчдынхаас илүү байлаа.

Спортын төв ордонд бэлтгэл сургуулилт хийдэг тамирчдын сэтгэл ханамж хамгийн бага байна.





## Түүвэр судалгааны үр дүн

Тамирчид дараах үзүүлэлтүүдэд дундаж үнэлгээнээс доогуур сэтгэл ханамжтай байна.

- Мөсний машин
- Хувцас угаалга
- Хоол зүйч
- Сэтгэл зүйч
- Агааржуулалт
- Бэлтгэлийн заал
- Эмнэлгийн үйлчилгээ
- Амрах байр, буудал
- Саун



### Түүвэр судалгааны үр дүн

Бэлтгэл, сургуулилттай холбоотой хүчин зүйлсэд хөнгөлөлт, урамшуулал авах бол чухам ямар төрлийн хөнгөлөлт, урамшуулал авах хүсэлтэй байгааг тодруулахад дараах дэмжлэгүүдийг нэрлэж байлаа.

- Сэтгэл зүй, хоол зүйн зөвлөгөө
- Гаргасан амжилтаас шалтгаалж хөнгөлөлт үзүүлэх
- Өсвөр, залуучуудыг дэмжих
- Бэлтгэл хийх газар
- Олон сар явбал бэлтгэлийн хөнгөлөлт
- Эмнэлгийн үйлчилгээ
- Дасгалжуулалтын дэмжлэг


Харин бэлтгэл, сургуулилтаа хэвийн үргэлжлүүлэхэд дараах асуудал хамгийн их саад болж байна.

- Санхүүгийн асуудал
- Бэлтгэлийн нөхцөл, орчин
- Бэртэл гэмтэл, эрүүл мэндийн асуудал

## Түүвэр судалгааны үр дүн

Таны зүгээс спорт байгууламжуудын үйл ажиллагаа болон үйлчилгээ үзүүлэх байдлыг цаашид хэрхэн сайжруулалт, шинэчлэл хийгээсэй гэж хүсэж байна вэ гэдгийг торуулахад дараах асуудлыг хамгийн их нэрлэж байлаа.

- Бэлтгэлийн заал
- Спортын бариа засалч
- Сэтгэл зүйч
- Спортын заал
- Амрах байр, буудал
- Хоол зүйч
- Мөсний машин
- Эмнэлгийн үйлчилгээ
- Спортын тоног төхөөрөмж
- Агааржуулалт
- Фитнесийн иж бүрэн тоног төхөөрөмж бүхий заал
- Хувцас солих өрөө, душ
- Спорт хоолны газар



## Шийдэл

Судалгааны үр дүнд үндэслэн зөвлөх баг шинээр байгуулагдах спорт цогцолборын үйл ажиллагааг дараах чиглэлд явуулах нь үр дүнтэй байна гэж үзэж байна.

1. **Бэлтгэлийн төв байгуулах**
2. **Тэмцээн зохион байгуулах**
3. **Нийтийн спорт арга хэмжээ зохион байгуулах**
4. **Энтертайнмент арга хэмжээ зохион байгуулах**






# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНАЛ БОЛГОЖ БҮЙ ХУВИЛБАР

5





**Үйл ажиллагааны голлох чиглэл:** Шинээр баригдаж буй спорт цогцолборын үндсэн үйл ажиллагааны чиглэл “Бэлтгэлийн төв” байх юм. Учир нь ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэгч өрсөлдөгч байхгүй бөгөөд тамирчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлчилгээг бүрэн хэмжээнд хүргэх боломжтой байна. Үйл ажиллагааны гол чиглэлийн дэргэд бусад үйлчилгээг хүргэх стратеги баримтлах нь үр дүнтэй.

**Үйл ажиллагааны чиглэлд зайлшгүй баримтлах зарчим:** Нийслэлийн харьяа байгууллагуудын болон яармаг орчмын хэрэглэгчдийг татахын тулд тухайн бүс нутаг болон үйл ажиллагааны онцлогийг харуулсан нэршлийг зайлшгүй баримтлах хэрэгтэй.

**Санал болгож буй нэр:** “Яармаг бэлтгэлийн төв” “Улаанбаатар спорт цогцолбор” г.м

## Бэлтгэлийн төв

- Үйл ажиллагааны 75 хувийг эзлэх

## Тэмцээн зохион байгуулах

- Үйл ажиллагааны 20 хувийг эзлэх

## Энтертайнмент арга хэмжээ зохион байгуулах

- Үйл ажиллагааны 5 хувийг эзлэх

### Ажиллах хуваарь:

Даваа

Лхагва

Мягмар

Пүрэв

Баасан

Бямба

Ням

Үндсэн үйл ажиллагаа болох тамирчдын бэлтгэл, сургуулилт хийгдэх үйл ажиллагаа үргэлжилнэ.

Бусад үйл ажиллагаа

## Бэлтгэлийн төвийн үйл ажиллагаа: Хэрэглэгчдийг татахдаа үнээр ялгарах, орчин нөхцөлөөр ялгарах стратеги баримтлах

### ОУ-ын хамтарсан бэлтгэл

- Спортын холбоодтой хамтын ажиллагаагаа баталгаажуулахад анхаарвал энэ төрлийн ажиллагааг урт хугацаандаа хамтран зохион байгуулах боломжтой
- Бөхийн спортын амжилтыг ашиглан гаднын тамирчдыг урих стратеги баримтлах

### Дотоодын тамирчдын бэлтгэл

- Нэн тэргүүнд холбоо барих шаардлагатай спортын тамирчид
- Орон нутгаас УАШТ-д оролцохоор ирсэн тамирчид

### Нэн тэргүүнд холбоо тогтоох шаардлагатай холбоод

- Усан спорт
- Сагсан бөмбөг
- И спорт
- Хөнгөн атлетик
- Хөл бөмбөг
- Чөлөөт бөх
- Волейбол
- Үндэсний бөх
- Жюү-жицу бөх
- Жүдо бөх
- Самбо бөх

### Зах зээлээс олох боломжтой орлого

- Улаанбаатар хотод тогтмол бэлтгэл сургуулилт хийж буй тамирчдын зарцуулж буй мөнгөн дүнгийн 1 хувьд нь хүрч чадвал жилд 1.0 тэрбум төгрөгийн орлого олох боломжтой
- Мөн УАШТ оролцохоор ирсэн орон нутгийн тамирчдыг байрлуулан бэлтгэл, сургуулилтыг хангаснаар орлогоо нэмэгдүүлэх боломжтой. Тэдгээр хүмүүст байрлах газар хамгийн чухал хэрэгцээтэй байдаг



## Бэлтгэлийн төвийн үйл ажиллагаа: Хэрэглэгчдийг татахдаа үнээр ялгарах, орчин нөхцөлөөр ялгарах стратеги баримтлах

### Давуу тал

- Байршиж бэлтгэл хийж буй тамирчдад цогц үйлчилгээг санал болгож байгаа тул цаг хугацаа хэмнэнэ
- Гадуур гарах шаардлага гарахгүй тул анхаарал төвлөрөлт дээд зэргээр хангагдана
- Агаарын бохирдол бага
- Мөсний машин гэх мэт тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан
- Гадна талбайн бэлтгэл хийх боломж (тухайлбал гүйх) бүрэн бүрдсэн
- Мэргэжлийн эмч, хоол зүйч, сэтгэл зүйч, бариа засалчийн үйлчилгээг хүссэн цагтаа авна
- Спортын менюээс өөрт тохирох хоолыг захиалан идэх боломжтой
- Олон улсын нисэх онгоцны буудалтай хамгийн ойр байршилтай тул давуу талтай

### Тамирчдад олгох хөнгөлөлт урамшуулал

- Сэтгэл зүй, хоол зүйн зөвлөгөө
- Гаргасан амжилтаас шалтгаалж хөнгөлөлт үзүүлэх
- Өсвөр, залуучуудыг дэмжих
- Бэлтгэл хийх газар
- Олон сар явбал бэлтгэлийн хөнгөлөлт
- Эмнэлгийн үйлчилгээ
- Дасгалжуулалтын дэмжлэг

### Зайлшгүй шаардлагатай зүйлс

- Тоног төхөөрөмжийг стандартын дагуу байлгах (Мөсний машин нэн тэргүүнд байх)
- Агааржуулалтыг бүрэн шийдэх
- Хувцас солих зориулалтын өрөөтэй байх
- Эмнэлгийн багтай байх
- Зочид буудал, амрах байр байх
- Бариа засалч, хоол зүйч, сэтгэл зүйчтэй байх
- Саун душийг стандартын дагуу бэлтгэх
- Хоолны газартай байх
- Спортын меню санал болгох
- Гадна бэлтгэл хийх талбайтай байх
- Хувцас угаах үйлчилгээ
- Автомашины зогсоол

### Зах зээлээс олох боломжтой орлого

- Улаанбаатар хотод тогтмол бэлтгэл сургуулилт хийж буй тамирчдын зарцуулж буй мөнгөн дүнгийн 1 хувьд нь хүрч чадвал жилд 1.0 тэрбум төгрөгийн орлого олох боломжтой
- Мөн УАШТ оролцохоор ирсэн орон нутгийн тамирчдыг байрлуулан бэлтгэл, сургуулилтыг хангаснаар орлогоо нэмэгдүүлэх боломжтой. Тэдгээр хүмүүст байрлах газар хамгийн чухал хэрэгцээтэй байдаг

## Бэлтгэлийн төвийн үйл ажиллагаа: **SWOT шинжилгээ**

### Давуу тал

- Цогц үйлчилгээ санал болгох-Тамирчид байрлах буудал, амрах байр, хөл . бөмбөгийн талбай, усан бассейн, фитнес, хувцас солих өрөө, душ, ресторан, стандартад нийцсэн тоног төхөөрөмж, авто зогсоол, хувцас угаах үйлчилгээ, бусад
- Олон төрлийн спортын үйл ажиллагаа нэгэн зэрэг зохион байгуулах боломжтой
- Шигшээ багийн бэлтгэл хийдэг газар (нэр хүнд)
- Олон Улсын нисэх онгоцны буудалтай ойр байршилтай
- Өрсөлдөгч байгууллагуудын нэвтрүүлээгүй үйл ажиллагааг зах зээлд нэвтрүүлэх
- Бүтэц орон тоо цомхон байх боломжтой, орон тооны багштай байх шаардлагагүй түрээслэх боломжтой
- Цаашид нэмэлтээр барилга байгууламж барих, өргөтгөх боломжтой

### Сул тал

- Санхүүжилт
- Авто замын түгжрэлтэй бүсэд байршдаг
- Ихэнх үйлчлүүлэгч нисэх, яармаг орчмын хүүхэд, залуучууд, иргэд байна
- Спортын тоног төхөөрөмжийн элэгдэл, хоргодол хурдан ядагдана
- Түрээслэгчийн тоног төхөөрөмжийг хадгалах агуулах, сав бэлдэх шаардлагатай болно
- Цогцолбор бүрэн баригдаж дуусаагүй (усан бассейн, гүйлтийн зам)

### Боломж

- Тамирчдад цогц үйлчилгээ санал болгох боломжтой, олон улсын тамирчид байрлаж хамтарсан бэлтгэл хийх болон тэмцээн уралдаанд оролцож буй тамирчид байрлах, амрах, бэлтгэл хийх боломжтой
- Зорьж ирэх үйлчлүүлэгчидтэй болох боломжтой, байгууллагын үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэнэ.
- Олон төрлийн спортын бэлтгэлийн нэгэн зэрэг хийх боломжтой
- Нисэх, Яармаг орчмын хүүхэд, залуучуудад тав тухтай орчинд спортоор хичээллэх боломжийг бий болгоно
- Орон нутгаас ирсэн тамирчид хамтарсан бэлтгэл хийх боломжтой
- Спортын ордонд байгаа бусад дагалдах үйлчилгээ (ресторан, кофе шоп, СУ, спортын хувцас, хэрэгсэл худалдах, АТМ байршуулах гм) –ний орлого нэмэгдэх боломжтой

### Аюул занал

- Бэлтгэлийн болон түрээсийн санхүүжилттэй холбоотой хугацаандаа төлбөрөө хийхгүй байх зэрэг асуудал үүсэх боломжтой
- Олон хүн цуглахад цэвэрлэгээ үйлчилгээний чанар, стандарт алдагдах магадлалтай
- Ажилчдын орон тоо, түүнийг дагасан зардлыг асуудал /үйлчилгээний ажилтан, клубийн дасгалжуулагч г.м/
- “Буянт-Ухаа” спорт цогцолбор шигшээ багийн бэлтгэл сургуулалтын төвтэй хамтран үйл ажиллагаа явуулахаар болсон
- Хот дотор байрлаж буй бэлтгэлийн төв учир тамирчдыг тогтвортой байлгах нь бэрхшээлтэй
- Ус, цахилгааны хэрэглээ их, ашиглалт, үйлчилгээний зардалтай байна
- Дуу чимээ ихтэй болох

Тэмцээн зохион байгуулах үйл ажиллагааны тухай : **Хэрэглэгчдийг татахдаа үнээр ялгарах стратеги баримтлах**

## ОУ-ын тэмцээн

- Спортын холбоодтой хамтын ажиллагаагаа баталгаажуулахад анхаарвал энэ төрлийн тэмцээнийг урт хугацаандаа зохион байгуулах боломжтой

## Дотоодын тэмцээн

- Улаанбаатар хотод өнгөрсөн жил 148 тэмцээн зохион байгуулагдсан бөгөөд энэ тоог тогтмол байна гэж тооцвол 10 орчим хувийг спорт цогцолбор дээр зохион байгуулах боломжийг эрэлхийлэх
- УАШТ-ийг зохион байгуулахад анхаарах хандуулах нь үр дүнтэй

## Нэн тэргүүнд холбоо тогтоох шаардлагатай холбоод

- Усан спорт
- Сагсан бөмбөг
- И спорт
- Хөнгөн атлетик
- Хөл бөмбөг
- Чөлөөт бөх
- Волейбол
- Үндэсний бөх
- Жюү-жицу бөх
- Жүдо бөх
- Самбо бөх

## Зах зээлээс олох боломжтой орлого

- Жилд дунджаар 15 тэмцээн зохион байгуулна гэж тооцвол 500,000,000 төгрөгийн орлого олох боломжтой гэж тооцлоо (Судлаачийн тооцоолол)
- Судалгааны үр дүнгээс үзэхэд жилийн 12 сарын хугацаанд тасралтгүй ямар нэгэн тэмцээн зохион байгуулагдаж байгаа билээ

## Тэмцээн зохион байгуулах үйл ажиллагааны тухай : Хэрэглэгчдийг татахдаа үнээр ялгарах стратеги баримтлах

### Давуу тал

- Цогц үйлчилгээ - Тамирчид байрлах буудал, амрах байр, хөл бөмбөгийн талбай, усан бассейн, фитнес, хувцас солих өрөө, душ, ресторан, стандартад нийцсэн тоног төхөөрөмж, авто зогсоол, хувцас угаах үйлчилгээ, бусад
- Нэг зэрэг олон спортын тэмцээн зохион байгуулах боломжтой
- Олон улсын нисэх онгоцны буудалтай ойрхон байршилтай

### Хөнгөлөлт урамшуулал

- Тогтмол хамтран ажилладаг холбоодод тэмцээн зохион байгуулахад түрээсийн хөнгөлөлт үзүүлэх

### Зайлшгүй шаардлагатай зүйлс

- Заал стандартын дагуу байх
- Агааржуулалт, гэрэлтүүлэг, халаалтыг бүрэн шийдсэн байх
- Лед болон 4 талтай унждаг дэлгэцтэй байх
- Хувцас солих өрөө, 00-ын өрөөнд зааланд болж байгаа тоглолтын талаарх мэдээлэл сонсогддог байх
- Хувцас солих, бие халаах зориулалтын өрөөтэй байх
- Хоол, худалдаа үйлчилгээний газартай байх
- Мэргэжлийн багтай байх /жишээ нь гэрэлтүүлэг дээр мэргэжлийн хүн байхаас гадна ажлын байран дээр тогтмол байх г.м/
- Эмнэлгийн түргэн тусламж үзүүлдэг байх
- Зочид буудал, байрлах газартай байх
- Бариа засалч, хоол зүйч, сэтгэл зүйч зэрэг нэмэлт үйлчилгээтэй байх
- Саун душ, нийтийн 00-ийг стандартын дагуу, цэвэрхэн байх
- Бэлэн мөс хэрэглэх боломжтой байх

### Зах зээлээс олох боломжтой орлого

- Жилд дунджаар 15 тэмцээн зохион байгуулна гэж тооцвол 500,000,000 төгрөгийн орлого олох боломжтой гэж тооцлоо (Судлаачийн тооцоолол)
- Судалгааны үр дүнгээс үзэхэд жилийн 12 сарын хугацаанд тасралтгүй ямар нэгэн тэмцээн зохион байгуулагдаж байгаа билээ

## Энтертайнмент арга хэмжээ зохион байгуулах: Хэрэглэгчдийг татахдаа үнээр ялгарах стратеги баримтлах

### Хэрэглэгчид

- Нийслэлийн харьяа байгууллагууд – ЕБС, СӨБ, НЗДТГ, Дүүргийн ЗДТГ-ууд, НХОГ, ХСХГ гэх мэт
- Томоохон байгууллагууд – Уул уурхай, банк санхүү гэх мэт

### Давуу тал

- Стандартын шаардлага хангасан заал, тоног төхөөрөмж
- Төрөл бүрийн спортын зөвлөгөө үйлчилгээ авах
- Үнэ хямд
- Хувцас угаах үйлчилгээтэй
- Автомашины хүртээмжтэй зогсоол

### Зайлшгүй шаардлагатай зүйлс

- Гэрэлтүүлэг, дуу, дефузер сайн, зориулалтын байх
- Тайзтай эсхүл тайз засах боломжтой байх
- Заал руу шууд машин орж болохоор зохион байгуулалттай байх
- Үйл ажиллагаа зохион байгуулагч баг амрах, байрлах өрөөтэй байх
- Автомашины зогсоол хүрэлцээтэй байх

### Зах зээлээс олох боломжтой орлого

- Жилд дунджаар 15 үйл ажиллагаа зохион байгуулна гэж тооцвол 500,000,000 төгрөгийн орлого олох боломжтой гэж тооцлоо. (Судлаачийн тооцоолол)

## Тэмцээн уралдаан зохион байгуулах, энтертайнмент үйл ажиллагаа: **SWOT шинжилгээ**

### Давуу тал

- Цогц үйлчилгээ санал болгох-Тамирчид болон урлагийнхан байрлах буудал, амрах байр, хөл . бөмбөгийн талбай, усан бассейн, фитнес, хувцас солих өрөө, душ, ресторан, стандартад нийцсэн тоног төхөөрөмж, авто зогсоол, хувцас угаах үйлчилгээ, бусад
- Олон улсын нисэх онгоцны буудалтай ойр байршилтай
- Олон төрлийн спортын тэмцээнийг нэг зэрэг зохион байгуулах боломжтой
- Заал руу гаднаас машин шууд орох боломжтой

### Сул тал

- Цогцолбор бүрэн баригдаж дуусаагүй
- Шоу, энтертайнментад зориулсан тоног төхөөрөмж, хөгжим, гэрэлтүүлэг байхгүй
- Ус, цахилгааны урсгал зардал өндөр гарах магадлалтай
- Үйлчилгээний ажилтнуудын ачаалал нэмэгдэнэ
- Тасалбар хяналтын тоног төхөөрөм байхгүй
- Нэмэлт харуул хамгаалалт авах хэрэгцээ үүсэх
- Элэгдэл хорогдол хурдасна
- Хотын төвөөс хол байршилтай (олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад эрсдэлтэй)

### Боломж

- Олон улсын болон орон нутгаас ирсэн тамирчдыг байршуулан тэмцээн уралдаан зохион байгуулах боломжтой
- Согтууруулах ундаа худалдаалах, үйлчлэх зөвшөөрөл авах боломжтой /Пиво-тэй тэмцээн хийх г.м/
- Хоол хүргэлтийн үйлчилгээ нэвтрүүлэх боломжтой
- Нэг дор олон төрлийн үйлчилгээ авах боломжтой
- Экспо хийхэд гадна талбай, ордны коридорыг ашиглах боломжтой

### Аюул занал

- Авто замын түгжрэлтэй бүсэд байршдаг
- Тэмцээн уралдаан, үйл ажиллагаа зохион байгуулахад ажилчид уртасгасан цагаар ажиллах тохиолдолд цалингийн зардал нэмэгдэх магадлалтай
- Барилга байгууламжид учрах эвдрэл, гэмтэл

## Спорт цогцолбор: **SWOT** шинжилгээ

### Давуу тал

- Цогц үйлчилгээ санал болгох-Тамирчид байрлах буудал, амрах байр, хөл . бөмбөгийн талбай, усан бассейн, фитнес, хувцас солих өрөө, душ, ресторан, стандартад нийцсэн тоног төхөөрөмж, авто зогсоол, хувцас угаах үйлчилгээ, бусад
- Олон төрлийн спортын үйл ажиллагаа нэгэн зэрэг зохион байгуулах боломжтой
- Шигшээ багийн бэлтгэл хийдэг газар (нэр хүнд)
- Олон Улсын нисэх онгоцны буудалтай ойр байршилтай
- Өрсөлдөгч байгууллагуудын нэвтрүүлээгүй үйл ажиллагааг зах зээлд нэвтрүүлэх
- Бүтэц орон тоо цомхон байх боломжтой, орон тооны багштай байх шаардлагагүй түрээслэх боломжтой
- Заал руу гаднаас машин шууд орох боломжтой
- Цаашид нэмэлтээр барилга байгууламж барих, өргөтгөх боломжтой

### Сул тал

- Санхүүжилт
- Авто замын түгжрэлтэй бүсэд байршдаг
- Ихэнх үйлчлүүлэгч нисэх, яармаг орчмын хүүхэд, залуучууд, иргэд байна
- Спортын тоног төхөөрөмж болон барилгын элэгдэл, хоргодол хурдан ядагдана
- Түрээслэгчийн тоног төхөөрөмжийг хадгалах агуулах, сав бэлдэх шаардлагатай болно
- Цогцолбор бүрэн баригдаж дуусаагүй (усан бассейн, гүйлтийн зам)
- Шоу, энтертайнментад зориулсан тоног төхөөрөмж, хөгжим, гэрэлтүүлэг байхгүй
- Ус, цахилгааны үрсгал зардал өндөр гарах магадлалтай
- Үйлчилгээний ажилтнуудын ачаалал нэмэгдэнэ
- Тасалбар хяналтын тоног төхөөрөм байхгүй
- Нэмэлт харуул хамгаалалт авах хэрэгцээ үүсэх
- Хотын төвөөс хол байршилтай (олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад эрсдэлтэй)



## Спорт цогцолбор: SWOT шинжилгээ

### Боломж

- Тамирчдад цогц үйлчилгээ санал болгох боломжтой, олон улсын тамирчид байрлаж хамтарсан бэлтгэл хийх болон тэмцээн уралдаанд оролцож буй тамирчид байрлах, амрах, бэлтгэл хийх боломжтой
- Олон улсын болон орон нутгаас ирсэн тамирчдыг байршуулан тэмцээн уралдаан зохион байгуулах боломжтой
- Нэг дор олон төрлийн үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлэх, хүлээн авах боломжтой
- Зорьж ирэх үйлчлүүлэгчидтэй болох боломжтой, байгууллагын үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэнэ.
- Нисэх, Яармаг орчмын хүүхэд, залуучуудад тав тухтай орчинд спортоор хичээллэх боломжийг бий болгоно
- Орон нутгаас ирсэн тамирчдад хамтарсан бэлтгэл хийх боломжтой
- Согтууруулах ундаа худалдаалах, үйлчлэх зөвшөөрөл авах боломжтой /Пиво-тэй тэмцээн хийх г.м/
- Хоол хүргэлтийн үйлчилгээ нэвтрүүлэх боломжтой
- Экспо хийхэд гадна талбай, ордны коридорыг ашиглах боломжтой
- Спортын ордонд байгаа бусад дагалдах үйлчилгээ (ресторан, кофе шоп, СУ, спортын хувцас, хэрэгсэл худалдах, АТМ байршуулах г.м) –ний орлого нэмэгдэх боломжтой

### Аюул занал

- Авто замын түгжрэлтэй бусад байрладаг
- Бэлтгэлийн болон түрээсийн санхүүжилттэй холбоотой хугацаандаа төлбөрөө хийхгүй байх зэрэг асуудал үүсэх боломжтой
- Олон хүн цуглахад цэвэрлэгээ үйлчилгээний чанар, стандарт алдагдах магадлалтай
- Тэмцээн уралдаан, үйл ажиллагаа зохион байгуулахад ажилчид уртасгасан цагаар ажиллах тохиолдолд цалингийн зардал нэмэгдэх магадлалтай
- Ажилчдын орон тоо, түүнийг дагасан зардлыг асуудал /үйлчилгээний ажилтан, клубийн дасгалжуулагч г.м/
- Барилга байгууламжид учрах эвдрэл, гэмтэл
- “Буянт-Ухаа” спорт цогцолбор шигшээ багийн бэлтгэл сургуулилтын төвтэй хамтран үйл ажиллагаа явуулахаар болсон
- Хот дотор байрлаж буй бэлтгэлийн төв учир тамирчдыг тогтвортой байлгах нь бэрхшээлтэй
- Ус, цахилгааны хэрэглээ их, ашиглалт, үйлчилгээний зардалтай байна
- Дуу чимээ ихтэй болох



# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

# ХАВСРАЛТ

6



Бид нар олимпын бэлтгэлээр Завханд, Өртөө толгойд гарсан. Жишээ нь Өртөө толгой байгаль сайтай, усан бассейн, саунтай ёстой гоё гэвч дэвжээ байхгүй, гадаа дэвжээ засаж бэлтгэлээ хийж байсан. Нар гарахаар түлэгдээд, бороо орохоор дэвжээн дээрээ халтирч унах гээд л. Эко руу байрлахаар агаар муутай, био тал руугаа болохоор цэвэрлэх байгууламжийн үнэр үнэртдэг гэх мэтээр асуудал ихтэй... бэлтгэлийн бааз цогцоороо шийдэгдсэн газар байхгүй.

...бүх спорт л бэлтгэл хийх орчин сайтай газар хайж байгаа.

Чанарын судалгааны үр дүнгээс

Тамирчдад барилга байгууламж, өрөөний агааржуулалт, нэг өрөөнд байрлах хүний тоо гэх мэт зүйлс их чухал байдаг. Тэмцээнд бэлдэж байгаа хүмүүс бүх зүйл маш мэдрэг болчихдог, тиймээс тамирчдын өрөө чимээ шуугианаас тусгаарлагдсан, цэвэр агаар, нарны гэрэл нэвтрэх боломжтой байх хэрэгтэй.

Чанарын судалгааны үр дүнгээс

Тамирчид хотод бэлтгэл хийхдээ зам дагаад кросст гүйдэг. Ер нь их эрсдэлтэй нөхцөлд бэлтгэл хийдэг гэсэн үг, гэрлэн дохио, замын гарц гэх мэт.

Чанарын судалгааны үр дүнгээс

Гадаадад бол хувцас угаагаад эвхээд өрөөний үүдэнд тавьчихсан байдаг. Ийм орчинд бэлтгэл маань илүү их үр дүнгээ өгч байгааг анзаарч байсан. Манай орчинд бол эсрэгээрээ, бэлтгэл хийж ядарчхаад дахиад л хувцсаа угаах гээд нэг угаалгын машин дээрээ оочирлоод л байж байна. Амармаар байдаг, хиртэй, хөлстэй хувцсаа угаамаар байдаг. Тэгэхдээ бид нарт бол өсвөр, залуу хүүхдүүд туслаад л хувцас угаагаад өгчихдөг. Одоо бол бараг л бид нараас 10 насаар дүү хүүхдүүд ирж байна шүү дээ. 2004 оных гэх зэрэг.

Чанарын судалгааны үр дүнгээс

Бассейн байвал бас их зүгээр, усанд сэлэхээр биеийн бүх булчин ажилладаг гэсэн дээрээс нь булчингуудыг маш сайхан суллаж өгдөг болохоор бүх спортын тамирчдад хэрэгтэй.

Чанарын судалгааны үр дүнгээс

Гадаадад зааландаа бүх спортын тоног төхөөрөмж хэрэглэлүүд нь байж байдаг. Манайд болохоор заал нь сагсны шийд, волейболын торноос өөр төхөөрөмжгүй байдаг болохоор ихэнх тоног төхөөрөмжүүдээ өөрсдөө зөөж явдаг.

Усныханд зориулсан хүчний бэлтгэл хийлгэдэг төхөөрөмжүүд байдаг тэр зориулалтын төхөөрөмжийг авчихвал маш хэрэгтэй. Өөр спортын тамирчид хэрэглэж бас болно. Лапатик орчуулахын бол хүрз гээд бид нар нэрлээд явчихдаг. Гартаа хийгээд усыг эсэргүүцэх талбайн хэмжээг томсгож байгаад илүү хүч гаргаж яг усан дээр сэлж байгаа юм шиг хөдөлгөөнөө хийх боломжтой болдог.

1-2 метрийн зөөврийн суурь хэрэгтэй байдаг. Суурийг хаалтад ч ашиглана, довтолгоо хийж байгаа хүн ч ашигладаг /волейбол/.

Бөмбөгний хүчийг тохируулж хамгаалагч өөр дээрээ авч сурдаг. Хэдэн зуун мянган удаа буудуулж байж хүчтэй ирж байгаа бөмбөгнөөс цочихгүй хүчийг нь бууруулж, биедээ шингээж авч сурдаг юм. Хүнээр цохиулаад байхаар цохиж байгаа хүн нь ядраад их хэцүү болдог юм. Бөмбөгний машин бол хүнээс гарч болох хамгийн дээд хурдыг тооцоолоод тохируулчихсан байдаг /волейбол/.

Бөмбөг талбайгаас гарах болон хүүхдүүд унаж бэртэхээс хамгаалсан хашлагатай байдаг, олон улсын хэмжээний хувьд урт нь 2 метр өндөр нь 1-1.20 метрийн хэмжээтэй хаалт 10 градусын налуутай /гадна тал руу/ хоёр талаараа байх ёстой. Хаалт нь хуванцар болон хөнгөн цагаанаар хийгдсэн байх ёстой, мөн энэ хаалтууд нь 2 талын шугамын үүргийг гүйцэтгэдэг. 2 талдаа том, хаалганы араар жижиг хаалттай байна /хараагүйчүүдийн хөл бөмбөг/.

Бидэнд зориулсан тусгай заал гэж байдаггүй. Ихэвчлэн сагс, волейболд зориулсан байдаг. Манайд байгаа ганц заал 1980 онд баригдсан. Энэ зааланд ихэнх тамирчид бэлтгэлээ хийнэ, дээрээс нь бусад спортын тамирчид ирж хүчний бэлтгэлээ хийдэг болохоор заалны хүрэлцээ маш муу байдаг /хүндийн өргөлт/.

Өвөл гүйж нормоо хангаж тэмцээндээ бэлдэхгүй бол зун амжилттай оролцож чадахгүй. Хөх хот, Япон гээд улсууд руу явдаг. Ерөнхийдөө бол хаана бэлтгэл хийх боломжтой байна, тийшээ л явна /хөнгөн атлетик/.

Чанарын судалгааны үр дүнгээс

Бэлтгэл сургуулилт хийх үед жижиг жижиг олон бэртэл авдаг, бас булчин чангарах үед эмчлэх эмч нар маш их хэрэгтэй. Энд байгаа эмч нар бол бидэнд уламжлалт талаасаа л судалж зөвлөгөө эмчилгээ үзүүлдэг, яг спортоор дагнасан эмч Монголд бараг байдаггүй байх. Тамирчид маш олон жижиг бэртэл авдаг, эмч нар бол тодорхой гэмтэл авсан үед тодорхой зөвлөгөө өгдөг, гэвч бид нарт бол бэртсэний дараа яаж гам барих, бэлтгэлдээ хэрхэн орох уу, ямар дасгал хөдөлгөөнөөр эхлэх үү гэх мэт зүйлс хамгийн чухал байдаг, өөрсдөө зөв бурууг нь мэдэхгүй баримжаагаараа л бэлтгэлдээ ордог.

Олон улсын тэмцээнд эмчийнхээ мандатыг төлж чадахгүй эмчгүй өөрсдөө тариа, дуслaa хийгээд орох үе хүртэл байдаг.

Чанарын судлгааны үр дүнгээс

Тамирчид амжилт үзүүлэхэд сэтгэл зүй их чухал байдаг, манайд дасгалжуулагч багш нар бидний сэтгэл зүйч болдог, эмч болдог.

Польшид бид нар 14 хоногийн бэлтгэл хийсэн юм. Тэнд олимпод орох гэж байгаа тамирчдын гэр бүлтэй нь аваад ирсэн байсан. Хүүхэд нь 5 сартай, ээж нь олимпод орох гэж байгаа, нөхөр нь хүүхдээ түрээд л явж байдаг, гэр бүлээрээ хооллоод л үнэхээр аз жаргалтай харагдаж байсан. Манай улсад нэг ч удаа хүүхэд, ар гэрийн хүмүүсийг авч ирж байгаагүй энэ жил анх удаа хүүхдүүдийг нь 5 дахь өдөр авч ирээд ээж дээр нь амралтын өдрүүдэд байлгаж байгаад явуулсан. Тэгэхээр багш нар хүртэл эмэгтэй хүн хүүхдээсээ хол олон хоног байхаар сэтгэл санаа хамаг юм нь хүүхэд рүүгээ явчихдаг юм байна, тайван бус байдаг юм байна гэдгийг анзаарч байгаа юм.

Чанарын судалгааны үр дүнгээс

Хоол, хүнс нь өөх тос багатай, хурдан шингэдэг мөн өдрийн илчлэгээ бүрэн авч чадахуйц байх шаардлагатай. Түүнчлэн тамирчдын нэг хэсэг нь жин хасах, зарим нь жин нэмэх, булчингийн масс нэмэх зэрэг өөр өөр зорилготой байдаг. Гэтэл нийтэд нь нэг л төрлийн хоол хүнс өгдөг болохоор их тохиромжгүй санагддаг. Хоол хүнс бол тамирчдад хамгийн чухал зүйл.

Тамирчин хүний амжилтыг бариад явъя гэвэл хоол дээр нь маш сайн анхаарах хэрэгтэй. Тэгж байж л хүүхэд өсөж явна. Бид нарт бол чанартай хоол бараг өгдөггүй. Энэ жилийн дэлхийн аваргаар багш нар хангалттай хоол хүнс өгчихсөн гээд байгаа юм, бид нар хоолоо ороод идье гэхээр ямар ч идэх сонирхол байхгүй. Маш их тостой, давс, амтлагч ихтэй байдаг. Бид нар идэхгүй байхаар тогооч нар нь багш нарт танай хүүхдүүд хоол өгөөд байхад идэхгүй цамаан байна гэдэг. Амттай дээрээс нь бид нарт хэрэгтэй зүйл байвал иднэ шүү дээ, гэтэл бид нарт хэрэгтэй зүйл нэг ч байхгүй болохоор бид нар иддэггүй. Ингээд л бид нарын хоолны материалаар тоглоод байдаг. Яг тамирчдын тогооч тусдаа байх нь чухал.

Чанарын судалгааны үр дүнгээс

Багш нарын ихэнх нь өмнө нь тамирчин байсан хүмүүс байдаг болохоор дээр үеийн аргаараа л зүтгүүлээд байдаг нь их хэцүү байдаг. Одоо нийгэм бүхэлдээ өөрчлөгдөж байхад бид ч бас дагаад өөрчлөгдөх хэрэгтэй. Багш нартаа сургалт орж бүх талын мэдлэгээр хангах хэрэгтэй.

Манайд ихэнхдээ тоглодог байсан хүмүүс хийж байна. Бид нарын мэддэг чаддаг зүйлс одоо хоцрогдоод байна, ганц волейбол гэлтгүй бүх спортын бэлтгэл сургуулилт хийх багш дасгалжуулагчдын бэлдэх хөгжүүлэх хэрэгтэй байгаа.

Дасгалжуулагч нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага маш их байна.

Боксын шигшээ баг маань Узбекистаны шигшээ багийн дасгалжуулагчийг, Жүдо дээр Япон улсын багш, чөлөөт бөх дээр Америкийн дасгалжуулагч, Таеквондо дээр Солонгосын дасгалжуулагч нарыг урьж ажиллуулж байсан.

Чанарын судалгааны үр дүнгээс



Дээр байгаа хүмүүс заа нэг жин хасна гээд байсан бясаа авчихъя, тамирчин юм чин зүрх, элэг хамгаалах нэг витамин авчихъя гээд томоор /бүдүүн баараг/ яваад байгаа юм. Ямар ч нарийн шинжилгээ судалгаа байхгүй. Яг тэр аваад ирсэн юм нь бид нарт үнэхээр хэрэгтэй ч юм уу, үгүй ч юм уу мэдэхгүй, яаж уухыг нь ч мэдэхгүй хайрцаг дээрээс нь орчуулаад л уудаг. Тэгээд мэддэг юм шиг нөгөөхөө өглөө бүр сэгсрээд л ууна. Хамгийн гол нь уугаад булчин үүнийг задлаад хүний биед хүргэж байна уу гэдэг нь маш чухал. Уугаад байгаа хэр нь хүний биеийн очих ёстой газраа очихгүй шууд гадагшлаад байж болно шүү дээ. Тиймээс ууж байх явцад нь шинжилгээ хийдэг байх хэрэгтэй. Хүн хүний эрхтэн тогтолцоо өөр өөрөөр ажилладаг шүү дээ.

Гадаадын тамирчид бол улсаас өгсөн зүйлсийг нь ууна, нэмээд өөрсдөө үнэтэй зүйлс авдаг. Гэтэл тэр үнэтэй зүйлс нь яг хэрэгтэй ч юм уу үгүй ч юм уу бид нар мэдэхгүй мөнгөө үрээд уугаад л байдаг.

Чанарын судалгааны үр дүнгээс

Манай хүчний бэлтгэл хийх арга барил, тоног төхөөрөмж их хоцрогдсон санагдаад байдаг. Өөр газар очихоор жижиг авсаархан хэр нь олон төрлийн булчин хөгжүүлдэг төхөөрөмжүүд байдаг. Манайд багш нарын үеийн үндсэн 2-3 төрлийн хүчний бэлтгэл хийж байгаа. Дотроос татах, цээж шахах гэх мэт.

Одоо бол тамирчид тус тусдаа фитнес дээр хийгээд байгаа юм. Яг бэлтгэлдээ гараад ирэхээр нөгөө үндсэн таталт, цээж шахалтаа л хийнэ. Төхөөрөмжүүдээ бид нар өөрсдөө авч ирсэн, тэр хэд дээрээ л хийдэг. Одоо бодоод байхад хүчний бэлтгэл, бөхийн багш нарыг нийлүүлж байгаад хүчний бэлтгэлийн багш гэж гаргаж ирэх хэрэгтэй юм байна. Манай Монголд бол хүндийн өргөлтийн тамирчид л өөрийн туршлага, хар ухаан дээрээ тулгуурлаад жаахан юм судалж байгаад хувь хувьдаа фитнес нээгээд тамирчдын хүчний бэлтгэлийг хийлгэдэг. Гэтэл яг чөлөөт бөхөд зориулагдсан ч юм уу, эсвэл спорт тус бүрд зориулагдсан хүчний бэлтгэлийн талаар тодорхой мэдлэгтэй хүмүүс бол их ховор байх.

Чанарын судалгааны үр дүнгээс

Тамирчдадаа бэлтгэлийн үеэр сунгалт зааж өгөх хэрэгтэй бас булчин тус бүрийг суллах аргыг заах хэрэгтэй. Багш нарт бэлтгэлийн дараа сунгалт хийлгэхгүй бол чангарсан булчин явсаар бэртэл болдог гэдгийг маш сайн ойлгуулах хэрэгтэй.

Чанарын судалгааны үр дүнгээс

Өмнө жил улсын аваргаа "Степпе арена"-д зохион байгуулсан. Өмнө нь болж байгаагүй гоё улсын аварга болсон. Том лед дэлгэц гаднаас түрээсэлсэн. Ихэнх спортынхон аннас, баннер хэвлүүлж мөнгөө үрдэг, жишээ нь манайх 1 сая төгрөг зарцуулдаг. Хэрэв байгууллагууд том лед дэлгэцтэй бол бид тэр газар луу илүүтэй очихыг хүснэ.

Тамирчдын оноолт түрүүлээд гарчихдаг болохоор лед дэлгэц дээр томоор харуулаад гаргачихвал амар байдаг. 2 барилдааны дараа Монгол улсын тамирчин гарах юм байна гэдгийг шууд хараад л мэдчихнэ.

Чанарын судалгааны үр дүнгээс

Тамирчид байрлах байр бас маш их хэрэгтэй. Манайх бол Баянголд байрлуулчихна, тэмцээн нь нисэхэд болно. Бид нарын тэмцээн өглөө 8 цагт жин үзээд, 10 цагт эхэлдэг. Бид нар жингээ тааруулахын тулд өглөө 6 цагаас босдог. Тэгээд түгжирнэ хол замд яваад тэмцээн дээрээ очих бол их хэцүү, ядраад очдог. Тэгэхээр бүх спорт байрлах боломжтой том комплекстой болох хэрэгтэй.

Чанарын судалгааны үр дүнгээс

Буянт-Ухаа дээр бол ганцхан буланд хуушуур, гоймон д зараад зогсож байдаг. Гаднын орнуудад тэмцээнд ороход хоол унд маш сайн байдаг. Бид нар тэмцээнийхээ дундуур гараад нэг хоол авч идэхэд л тухайн орны хоолны соёл түгээж байдаг, дээрээс нь маш их орлого олж байгаа. Сая насанд хүрэгчдийн Азийн аварга манайд болоход нэг л хоолны газар ажиллаж байсан. Тэгээд нэг ажиллаж байгаа нь бараг хоолгүй, орчин муутай. Гаднын улсуудаас ирж байгаа хүмүүс бас хоолны соёл, үйлчилгээгээр биднийг үнэлж байгаа шүү дээ.

Тэмцээний дундуур тамирчид чинь дээшээ нэг дэлгүүр лүү ороод юм авчихдаг байвал. Хэдий ялагдсан ч гэсэн дараагийн хүмүүсийг үзээд мэхийг нь хараад чипс идээд суумаар л байдаг шүү дээ. Нисэхээс бол дэлгүүр ч олддоггүй.

Тамирчны өөрийн оролцож байгаа төрөл дуусаад бусад төрлийн тэмцээн болж байх хугацаанд нь дэлгүүр хэсээд нэг подволк ч юм уу үзээд, хоол идээд, амттай юм идээд явж баймаар байдаг. Гаднын аренанууд Буянт-Ухаатай яг адилхан, тэгэхдээ булан бүр дээр нь янз бүрийн юм зараад байж байдаг. Хувцас хэрэгсэл, хоол, амттан, улсынхаа онцлогийн харуулсан соёлын зүйл хүртэл зараад улсаа рекламдаад л байж байдаг.

Чанарын судалгааны үр дүнгээс

Хүний суудал тухтай байх нь цаагуураа олон хүн цуглах, үзэх боломжийг нэмэгдүүлж байдаг.

Байнгын ашигтай үйл ажиллагаатай байлгая гэж бодож байгаа бол тэр талбайг олон янзаар ашиглах боломжийг нэмэх хэрэгтэй. Үзэгчдийн суудлыг хойш нь хураачих юм бол хөл бөмбөгийн 2 талбай, волейболын 4 талбай, сагсны 4 талбай гарах боломжтой.

Чанарын судалгааны үр дүнгээс

Бие халаалтын өрөө байвал маш амар. Бид нар 1 минутын дотор захиалга өгөөд өргөх ёстой байдаг учраас бие халаалтын өрөө ойрхон байх хэрэгтэй. Бие халаалтын өрөө нь 4x4 –ийн хэмжээтэй 6 дэвжээ багтдаг байхад хангалттай.

Чанарын судалгааны үр дүнгээс

Хувцас солих өрөө дотроо ариун цэврийн өрөө, саун дүүш, зөөлөвчтэй сандал зэрэг бүгдийг нь стандартынх нь дагуу шийдчихсэн байх хэрэгтэй. Мөн зааланд болж байгаа зүйлс өрөөнд сонсогддог байх ёстой. Тамирчдыг хувцас солих өрөөндөө сууж байхад, 00-д байхад, үсээ сүлжүүлж байхад гэнэт нэр дуудах үе их байдаг.

Олон улсын тэмцээнд тамирчдын хувцас солих өрөөг улс улсаар нь гаргаж өгдөг бөгөөд хаалган дээрээ улсынх нь тугтай байдаг. Буянт-Ухаад Азийн аварга болоход бид нар дэвжээн дээрээ хувцсаа сольсон.

Хувцас солих өрөөнд самбар байх юм бол багаараа төлөвлөгөөгөө ярилцаад хэлэлцэхэд их зүгээр юм байна лээ.

Хувцас солих өрөө нь дотроо 00, дүүштэй байх хэрэгтэй. 00, дүүшийг манайхан зөвхөн Ази хүмүүст зориулаад маш жижиг хийчихдэг. Тэгж болохгүй нэгэнт л барьж байгаа юм чинь стандартын дагуу, бүх хүн багтахаар хийх хэрэгтэй.

Хувцасны өрөөгөө 4 байлгах хэрэгтэй. 2 баг хувцсаа солиод гарч байхад, дараагийн 2 баг орж ирж хувцсаа солино тийм болохоор 4 өрөө байх зайлшгүй шаардлагатай. Тэр дундаа олон улсын тэмцээн, манайхан хэнэггүйтээд 2 хувцас солих өрөө хийчихдэг, тэгээд л хулгай гэх мэт асуудал их үүснэ.

Чанарын судалгаан үр дүнгээс

Степпе аренад Мобинет байж байдаг бид нар Юнивишн авах гээд нэмэлтээр аймар их мөнгө төлөх шаардлага гардаг. Ямар ч эвент хийсэн тухайн шилэн кабел руугаа холбоод холболт хийхэд болдог байвал зүгээр, 10 компьютерыг ажиллуулах интернэтэд манайх 1,000,000 орчим төгрөгийг зарцуулж авдаг.

Чанарын судалгааны үр дүнгээс